

## **АГУУЛГА**

Өмнөх үг..... 2

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

Хэвлэлийн өөрийн зохицуулалт ..... 4

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

Харьцуулсан судалгаа..... 10

2.1 Данийн Хэвлэлийн Консул ..... 10

2.2 Их Британийн Хэвлэлийн Консул..... 18

2.3 Недерландын Хэвлэлийн Консул ..... 28

2.4 Шведийн Хэвлэлийн Консул ..... 34

2.5 Босни-Герциговинийн Хэвлэлийн Консул ..... 40

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

Дүгнэлт, зөвлөмж ..... 49

3.1 Дүгнэлт ..... 49

3.2 Зөвлөмж ..... 57

Хэвлэлийн Консултай холбоотой Интернет дэх мэдээллийн эх сурвалжууд.... 59

## ӨМНӨХ ҮГ

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хэвлэл, мэдээллийн Эрх чөлөөний тухай хуулийн<sup>3</sup> хэрэгжилтийг эргэн харж, зарим нэг нэмэлт өөрчлөлт оруулахаар судалж байна. Энд хэвлэл мэдээллийн анхаарлыг хандуулж сэтгүүлчдийн мэргэжлийн ашиг сонирхлыг хамгаалах нь чухал ач холбогдолтой гэж үзэж Монголын хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг дэмжих зорилгын үүднээс Нээлттэй нийгэм Форум, Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яамтай хамтран зарим улсын хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм, Хэвлэлийн Консулуудыг харьцуулсан судалгааг хийлээ.

Эрх баригчдын дарамт шахалтаар биш сэтгүүлчдийн өөрсдийн санаачилгаар хэвлэлийн хариуцлагын систем, өөрийгөө зохицуулах механизм болох Хэвлэлийн Консул байгуулснаар цаашдаа хэвлэл мэдээллийг болзошгүй хууль эрх зүйн дарамтаас урьдчилан сэргийлэх, сэтгүүлчдэд тохирсон шударга хариуцлага хүлээлгэх, нийгмийн өмнө хэвлэлийн хариуцлагыг нэмж нэр төрийг өндөрт өргөснөөр нээлттэй тунгалаг нийгэм байгуулахад зайлшгүй шаардлагатай гэж судлаачийн зүгээс үзэж байна.

**Судлах шаардлага:** Сэтгүүлчид бид Хэвлэлийн Консул, сэтгүүлчийн ёс зүйн хорооны тухай ярьсаар бараг 17 жил болжээ. Сэтгүүл зүйн ёс зүй нь хэрэгжүүлэх механизм байхгүй бол хоосон талд цуурай болон үлдэх болно.

Хэвлэлийн өөрөө өөрийгөө зохицуулах механизм болон сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэх Хэвлэлийн Консул нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээлэлд мэргэжлийн шаардлага стандарт тогтоож, улмаар олон нийтийн зүгээс хэвлэлд хандах хандлагыг сайжруулах, эрх баригчид, Засгийн газрын зүгээс хэвлэлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох явдлыг урт хугацаандаа хязгаарлах болно.

**Судлах зүйл:** Дэлхий дээр нийтдээ 54 улсад<sup>4</sup> хэвлэлийн өөрийн зохицуулалтын тогтолцоо болох Хэвлэлийн Консул байгаагаас судалгаанд Англо-Саксон ардчилалтай, өндөр хөгжилтэй орнууд, хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизмын эртний уламжлалтай Скандинав, шилжилтийн үедээ байгаа Зүүн Европын орнуудын Хэвлэлийн Консулыг онцлон сонгож хамруулж, Дани, Их Британи, Недерланд, Швед, Босни-Герциговийн Хэвлэлийн Консулаар жишээ татаж задлан шинжиллээ. Хэвлэлийн Консулын талаар Хэвлэлийн Эрх чөлөөний тухай хуулинд нэмэлт заалт орох зайлшгүй хэрэгтэй юу гэсэн асуултанд үндэслэлтэй хариулахыг хичээлээ.

---

<sup>3</sup> Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 1998 он

<sup>4</sup> Энэ тоо Африкийн Хэвлэлийн обсерваторийг оролцуулбал 65, зарим хагас дутуу ажиллаж байгааг нэмбэл 80 болно.

**Судалгааны зорилт:** Монгол улсад хэвлэл мэдээллийн өөрөө өөрийгөө зохицуулах механизм, Хэвлэлийн Консул байгуулахад тулгарч болох асуудал, цаашид хөгжих боломжийг сайжруулах санал дүгнэлт гаргахад оршино. Энэ судалгаа нь хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид, хууль тогтоогчдод бусад улсын хэвлэлийн туршлагыг харьцуулах боломж олгох, хэрэв хуулийн шинэ заалтууд нэмэгдэх бол үндэслэл болох практик ач холбогдолтой юм.

**Судалгааны ажлын бүтэц:** Судалгааг энгийн, ойлгомжтой, фокус сайтай болгох үүднээс тухайн Хэвлэлийн Консул бүрийг дараах сэдвээр шинжилсэн болно.

- Хэвлэлийн Консулын үүрэг
- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт
- Санхүүжилтийн эх үүсвэр
- Дүрэм журам
- Өргөдөл шийдвэрлэх механизм
- Шийдвэрийг олон нийтэд мэдээлэх
- Хууль зүй болон бусад асуудлууд

Энэ ажил нь 3 бүлэг, 5 зүйл, дүгнэлт, зөвлөмж, Хэвлэлийн Консулын тухай мэдээллийн эх сурвалж бүхий хавсралтаас бүрдэнэ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүлээн зөвшөөрч дэмжсэн төрийн бодлогын хувилбаруудыг олон нийтийн санаа бодолд тулгуурлан дэвшүүлж, өнөөдөр хэрэгжиж байгаа хуулийг арьс махаараа мэдэрдэг хэвлэл сэтгүүлчдийн санаа бодлыг сонсож хэлэлцүүлье. Зүгээр нэг ном интернэт шагайж байгаад ийм асуудал байна, ингэж шийдмээр байна гэхээсээ илүү, сэтгүүлчдэд хүмүүст ийм бэрхшээл байна, үүнийгээ шийдүүлэхийг хүсч байна, иймэрхүү байвал зүгээр гэж бодож байна гэдэгт тулгуурлахыг хичээж судаллаа.



# БҮЛЭГ

## ХЭВЛЭЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

### Хэвлэлд тулгарсан асуудал

Чөлөөт нийгмийн тулгуур үзэл санаа механизм болох ардчилал, эрх зүйт ёсны төлөө тэмцэл өдөр бүр үргэлжилж байна. Өнөөдрийнх шиг хэн хүчтэй, хэн мөнгөтэй, хэн эрх мэдэлтэй, хэн галзуу мэт аашилсан нь асуудлаа шийдүүлж хүчирхийлдэг байж болохгүй билээ. Чөлөөт хэвлэл гэдэг нь хэсэг бүлэг хүн хэнээс ч үл хамаарч үзэл бодлоо хэвлэлээр илэрхийлэхийн нэр. Хүмүүс ярилцаж, ойлголцож зөвшилцөж, шударга ёсыг ардчиллаар тогтоодог. Гэтэл энэ ардчиллын тулгуур болж байгаа чөлөөт хэвлэл мэдээллийг боомилохыг оролдож, практикт хуулийг сэтгүүлчдийн эсрэг ашиглах тохиолдол олширлоо.

“Эрх баригчдын зүгээс иргэн хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд учруулж буй аюул улам бодитой боллоо.”<sup>3</sup> гэж өдөр тутмын сонинууд саяхан анхаарууллаа.

Сүүлийн жилүүдэд Монголын хэвлэл мэдээллийнхний санааг зовоосон гурван төрлийн асуудал байна гэж сэтгүүлчид хэлж байна. Нэгдүгээрт гүтгэлгийн хэргийн тоо байнга өссөн, хоёрдугаарт эрх баригчид зарим сонинийг хаасан явдал, гуравдугаарт сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүнд унаж байгаа явдал юм.<sup>4</sup>

1991 онд гүтгэлгийн 7 хэрэг гарсан бол 2000 онд 39 ийм хэрэг гарсан. Мөн 1999-2000 оны хооронд гүтгэлгийн 4 эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.<sup>5</sup> Хамгийн сүүлийн тод жишээ нь “Ардын Эрх” сониний сэтгүүлч Ц.Эрдэнэцэцэг,<sup>6</sup> “Өдрийн сонин” сониний сэтгүүлч

<sup>3</sup> “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны шуудан”, “Ардын Эрх”, “Монголын мэдээ”, “Үнэн” сониний хамтарсан мэдэгдэл 2007.09.05

<sup>4</sup> Монгол Улс шилжилтийн үед: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ, Article 19 / Globe International, London, 2002 оны 7-р сар

<sup>5</sup> 2002 оны долдугаар сард “Үг” сониний эрхлэгч Б. Хандолгорыг 6 сараар баривчилжээ. 2004 оны дөрөвдүгээр сарын 27-ны өдөр “Монголын нэг өдөр” сониний сурвалжлагч А.Эрдэнэтуяаг Эрүүгийн Хуулийн 111-р зүйлийн 2-р хэсэгт заасны дагуу Баянзүрх дүүргийн шүүхээс гурван сар баривчлах ял ногдуулжээ.

<sup>6</sup> Хүний нэр төрийг гутаасан гэж сэтгүүлч Ц.Эрдэнэцэцэгт иргэний хэрэг үүсгэжээ. “Ардын эрх” сониний 2006 оны арваннэгдүгээр сарын 22-ны No227-д нийтлэгдсэн “Хятад иргэн осол гаргаж, цагдаагийн ажилтнууд хэргийг дарсан уу?” зэрэг сурвалжлагыг ийнхүү буруутгажээ.

тоймч Г.Дашрэнцэн, “Зууны мэдээ” өдөр тутмын сонины сэтгүүлч Б.Цогнэмэх<sup>7</sup>, тус сонины эрхлэгч Б.Ганболд, Засгийн газрын Хэвлэлийн албаны дарга асан Н.Дэмбэрэл нарыг өөрсдийг нь шүүмжилсний төлөө эрх баригчид шүүхэд өгч заргалдсан явдал юм. Энэ нь Эрүүгийн хатуу хуулиар иргэд сэтгүүлчдийг залхааж айлгах гэсэн улстөрчдийн захиалгат ажиллагаа гэж сэтгүүлчид үзэж байна.<sup>8</sup>

“Бичсэн нийтлэл, сурвалжлагынхаа төлөө хариуцлага хvlээдэг байхыг ор тас vгvй-сгээгvй юм шvv. Гэхдээ Эрvvгийн хуулиар бус, Иргэний хуулиар шийтгvлдэг байя” гэж Г.Дашрэнцэн хэлж байна.

Эрүүгийн хуулинд доромжилсон бол нэг сар, гүтгэсэн бол дөрвөн сар хорино гэсэн заалт бий.<sup>9</sup> Хэвлэн нийтэлсний төлөө эрүүгийн хариуцлагад татахгүй байх НҮБ-ын уриалгыг<sup>10</sup> дэмжиж Монголын өдөр тутмын сонинууд тэргүүлсэн 35 сонины сэтгүүлчид “Өөрсдийг нь хонины хороонд хаших гэсэн оролдлого, санаархлын эсрэг” гэх лоозонтойгоор уриалга гаргаж нэгджээ.<sup>11</sup> Сүүлийн 10 гаруй жилд Европын орнуудаас гүтгэлгийн хэргээр нэг ч сэтгүүлч хорих болон баривчлах ялаар шийтгүүлээгүй байтал манайд ийм хэрэгт холбогдсон сэтгүүлчдийн тоо өсч байгаа нь санаа зовоож байна.<sup>12</sup>

2000 онд 21 сонин, 1 телевизийн станцад торгууль оногдуулж, 3 сонинг бүртгэлээс хасч, үйл ажиллагааг нь зогсоосон байна.<sup>13</sup> Харин 2007 онд “Зуун мэдээ” сонинг эрхлэн гаргагчид солигдсон нь улстөрчдийн зүгээс үзүүлсэн хууль, эдийн засгийн дарамт шахалтаас болсон гэж хуучин эзэн нь мэдэгджээ. Ийнхүү эрх баригчид хэвлэлийг хардаж, хувийн нэр хүнд, иргэний байр суурь ярьсаар хувийн ашиг сонирхлоо хамгаалж гүйцэлдүүлж байна.

Мэргэжил болгон эрсдэлтэй байдаг хэдий ч сэтгүүлчийн мэргэжил нь нууж хаасныг нээлттэй болгодог учраас бусдаас илүү эрсдэлтэй болгож байна.

<sup>7</sup> “Зууны мэдээ” сонины сурвалжлагч Б.Цогнэмэх УИХ-ын гишүүн Ч.Улааны талаар “Ялааны алуур”, “Увайгүй Улааны шинэ атак эхэллээ”, “Улааны урт гар Х.Баатарыг дахин амилуулав” зэрэг цуврал нийтлэл бичсэний төлөө эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байна. Эрхэм гишүүн сэтгүүлчийг өөрийг нь доромжилсон, гүтгэсэн гэж үзжээ.

<sup>8</sup> “Нийгмийн толь” 211 (303) 2007 он

<sup>9</sup> 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн Монгол Улсын Эрүүгийн хуульд төр, алдар хүндийг гутаах зорилгоор гүтгэх, доромжлох заалтуудад “хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан бол” хэмээн онцлон оруулжээ.

<sup>10</sup> 2002 оны 12 дугаар сарын 1-нд НҮБ Тунхаг бичигтээ өөрийн гишүүн орнуудад хандан “Эрүүгийн хуулиасаа гүтгэлэг, доромжлолын эсрэг заалтуудыг хасаж, Иргэний хуулиар зохицуулах”-ыг уриалжээ.

<sup>11</sup> 2007.09.07 Н.Дэмбэрэлийг шоронд хорьсонтой холбогдуулан сэтгүүлчдийн зүгээс хийсэн хэвлэлийн бага хурал.

<sup>12</sup> “Оршихын Цэрэндорж бол Цэдэнбалын засаглалын үед 1969 онд бичсэн зүйлээсээ болж аавын хаалга татсан байна. Үүнээс хойш олон олон Засгийн үед ийм явдал давтагдахгүй явсаар шинэ ардчилсан Монголын үед цөөнгүй сэтгүүлч ээлжлэн шоронд оров. Чөлөөт мэдээллийн хэрэгслийн тухай ойлголт байгаагүй хуучин коммунист нийгэмд алдаа гаргасан сайндаа л сэтгүүлчид намаасаа хусагдах, ажлаасаа донго авах төдий байсан бол шинэ нийгэмд илүү серёзний байна” Б.Баабар “Хэвлэлд ээлтэй хүн” 2004.05.03

<sup>13</sup> 2000 оны 9 дүгээр сард Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний татварын газар, Хэвлэлийн хүрээлэнгээс 150 сонин, 50 сэтгүүл, болон бусад 70 хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуультай хэр нийцэж байгааг шалгаад ийнхүү хаажээ.

## **“Сэтгүүлчид ядуу, айдас, авилгалтай байгаа нөхцөлд хэвлэлийн эрх чөлөө байхгүй”**

Өнөөдөр хэрэгжиж байгаа ЗЗ0-аад хуулийн нэг болох Хэвлэл мэдээллийн Эрх чөлөөний тухай хууль Монгол улс дахь хэвлэл мэдээллийн харилцааг үндсэнд нь зохицуулж байна. Үүний зэрэгцээ сэтгүүлчдэд халгаатай Эрүүгийн хуулийн хоёр заалтаар далимдуулан эрх баригчид хэвлэл мэдээллийг дарамтлахыг оролдох нь маргааны гол сэдэв болж байна. Мөн Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль, хэвлэл мэдээллийн өөрөө өөрийгөө зохицуулах механизм, хардах эрх, сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах эрхтэй байх талаар эрх зүйн зохицуулалт хэрэгтэй гэж сэтгүүлчид үзэж байна.<sup>14</sup> “Ардчилал хэд наслах нь мэдээлэл, үзэл бодлын чөлөөт урсгалаас хамаарна” гэж АНУ-ын сенатор Хиллари Клинтон хэлжээ.

Дээрх бодит байдлууд бол манай улсын эрх зүйн буруу зохицуулалтын илрэл юм. Гэтэл мэргэжлийн нэр хүндийг унагаж байгаа гэж үзэж сэтгүүлчдийн эмзэглэж байгаа өөр нэг шалтгаан нь зарим хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийнх нь хариуцлага хүлээхгүй байх гэсэн үйл ажиллагаа юм.

“Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөт байдал нийгэм эдийн засаг, улс төр, хууль эрх зүйн орчноос шалтгаалаад зогсохгүй сэтгүүлчдийн үзэл санаа, мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролтой салшгүй холбоотой байна” гэж хэвлэл мэдээллийг сүүлийн жилүүдэд тогтмол ажиглаж байгаа Монголын Хэвлэлийн хүрээлэн судалгааны тайландаа өгүүлжээ.<sup>15</sup> Монголд хэвлээгүйн төлөө зарим хэвлэл мөнгө авдаг. Хэвлэлийг айлгах хэрэгсэл болгодог пиарын захиалгат нийтлэл нэвтрүүлгүүд их тааралдана. Энэ бүгдийн эцэст хэрэв хэрэг явдал буруутвал өрсөлдөгчөө хэвлэлээр намнахаар захиалсан улстөрч эсвэл бизнесмэн, дайралтыг зохион байгуулсан пиарчин, сурталчилгааны төлбөрөө авсан хэвлэлийн эзэд гэмгүй үлдэж, харин сар бүр зуун ам.долларын цалингаа аваад редакцийн даалгавраар явж нийтлэл бичсэн сэтгүүлч цагдаагийн үүд сахих болдог юм. Сүрдүүлэг, зусардах-өөлөх, гүтгэх-магтах явдал асар их газар авчээ. Захиалагчдаа татахын тулд сугалаа урамшуулал тараана. Сэтгүүлчийн мэргэжлийн нэр хүндийг унагаж байгаа зүйлийн нэг нь энэ. Бичсэн зүйлийнхээ цэг таслал болгоны төлөө хариуцлага хүлээдэг хариуцлагатай хэвлэл, сайн сэтгүүл зүйн тогтолцоо бий болгох нь өнөөдрийн Монголын хэвлэлд хурцхан асуудал болоод байна.

## **Яагаад заавал хэвлэл мэдээлэл өөрөө өөрийгөө зохицуулах хэрэгтэй гэж?**

Нийгэмд юуг хийх ёстой вэ, юуг хийх ёсгүй вэ гэсэн хэмжээс байх ёстой. Ёс суртахууны хэм хэмжээ тогтоож, үнэт зүйлтэй болох ёстой. Тиймээс хэвлэлийн хариуцлагын тогтолцооны зохицуулалт зайлшгүй хэрэгтэй.

Хэвлэлийн эрх чөлөөг хэт тунхагласнаас эрх баригчид үүн дээр дөрөөлж хэвлэлийг “зохистой хэмжээнд байлгахгаар” баталгаажуулсан хууль тогтоомж гаргах шалтаг болгож, хатуу хуулиар зохицуулахыг оролдох болжээ.

---

<sup>14</sup> Нээлттэй Нийгэм Форумаас зохион байгуулсан Сэтгүүлч, хуульчдын уулзалт. 2007 оны 7 дугаар сар

<sup>15</sup> “Монгол дахь мэдээллийн эрх чөлөө” судалгааны тайлан 2005

Гэтэл үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахын тулд хэвлэл мэдээлэл нь Засгийн газар, төрийн хяналтаас ангид байх нь зайлшгүй шаардлагатай. Ингэснээр хэвлэл мэдээлэлд олон нийтийн хоточ нохой байх үүргээ биелүүлэх боломжийг олгож, ялангуяа нийтийн ашиг сонирхлын асуудлаар өргөн хүрээтэй санал бодлыг олон нийт хүлээж авах явдлыг хангана. Үүний тулд хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулах эрх мэдэлтэй байгууллагууд хараат бус байх бөгөөд улс төрийн нөлөөллөөс хамгаалагдсан байх ёстой. Хэвлэл мэдээллийн зохицуулалтыг төрөөс хараат бус байлгах арга нь хэвлэлийн өөрөө өөрийгөө зохицуулах механизм байдаг.

*Чөлөөт хэвлэл дэх өөрийн зохицуулалт нь Сэтгүүлчдийн дагаж баримтлах ёс зүйн зарчим болон Хэвлэлийн өөрөө өөрийгөө удирдах байгууллагаар зохицуулагдана.*

Эрх чөлөө, хариуцлага нэг зоосны хоёр тал юм. Хэвлэлийн эрх чөлөөг эдлэхтэй зэрэгцэж нийгмийн өмнө хүлээх хариуцлага хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонинд оногддог бөгөөд сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх ёстойг сэтгүүлчид ойлгодог. Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцлагагүй хандвал олон түмний дэмжлэгийг алдаж, улмаар дөрөв дэх засаглал гэж хичнээн чанга хашгираад ч үр дүн нь хоосон талд цуурай мэт үлдэнэ. Хэвлэл хүмүүст таалагдаж байж захиалга, сурталчилгааны их ашиг олно. Чухам энэ ашгийн төлөө хэвлэл үнэн зөв, бодитой, дундыг баримталсан, сонирхолтой мэдээллийг түгээнэ. Үүнийг дагаад ёс зүйн асуудал дагалдана. Ёс зүйтэй байж л олон түмний итгэлийг байнга хүлээнэ. Чөлөөт хэвлэл зөвхөн олон түмнээс, өөрөөр хэлбэл зах зээлээсээ хамааралтай.<sup>16</sup> “Сэтгүүл зүйд хүний эрхийг хамгаалах, хүний эрхийг хэрэгжүүлэх, өөрөө хүний эрхийг ямар нэг хэлбэрээр зөрчихгүй байх номлол хэрэгтэй байна” гэж сэтгүүлч Х.Цэвлээ үзэж байгаа бөгөөд тэр номлол нь чухамдаа нийгмийн хариуцлагатай сэтгүүл зүй хэмээх хүрээнд багтаж байгаа юм.<sup>17</sup>

Сэтгүүл зүйн хариуцлагыг дээшлүүлж, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоохын зорилго нь яваандаа хэвлэлийн эрх чөлөөний соёл, уламжлалыг Монголд бий болгох явдал юм. Энэ эцсийн үр дүнд амжилттай хүрэх арга зам нь Хэвлэлийн өөрийн зохицуулалт, үүн дотроо Хэвлэлийн Консул байгуулах нь үр дүнтэй арга гэсэн нэгдсэн дүгнэлтэнд судлаачид хүрч байна.

*Хэвлэлийн Консул гэдэг нь Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдүүлэх, нөгөөтэйгүүр сэтгүүлчдийг хамгаалах, сэтгүүлчийн нэрээр хаягласан гомдлыг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх журмаар шийддэг байгууллага.*

Энэ байгууллагын үйл ажиллагаа нь бичгээр илэрхийлсэн Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх үйл ажиллагаа байх юм. Ийм байгууллага хэрэгтэй гэдгийг сэтгүүлчид болон олон нийт хүлээн зөвшөөрч байгааг удаа дараагийн судалгаа харуулж байна.<sup>18</sup> Хэвлэлийн Консул нь хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, сэтгүүлчдийг шүүхээр айлган сүрдүүлэхээс аврах нэг арга төдийгүй бодлого боловсруулах болон

<sup>16</sup> Б.Баабар “Хэвлэлд ээлтэй хүн” 2004.05.03

<sup>17</sup> Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч Х.Цэвлээтэй хийсэн ярилцлага, 2007 оны 5 дугаар сар

<sup>18</sup> “Чөлөөтэй бөгөөд шударга байх нь” судалгааны тайлан, “Глоб Интернэшнл”, 2004 он

эрх зүйн хүрээнд Хэвлэлийн эрх чөлөөний үзэл санаатай холбоотой асуудал үүссэн тохиолдолд олон нийтийн эрх ашгийг, үнэн бодит мэдээллээр дамжуулан олон нийтэд төрийг хянах боломж олгодог хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах нэг бүтэц болно.

Хэвлэл мэдээллийн үүрэг нь төрийг засагладаг засаглал буюу дөрөв дэх засаглал юм. Энэ засаглалыг явуулж байгаа сэтгүүлчид дотроо засаглалтай байх хэрэгтэй. Энэ засаглал нь сэтгүүлчийн ёс зүйн зарчим байх юм. Хуулинд хэвлэлийн тухай заалт байдаг ч энэ нь хууль зөрчвөл хуулийн өмнө хариуцлага хүлээх тухай ярьж байгаа болохоос хэвлэл мэдээллийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага энд орхигддог юм. Хэвлэлийн Консул бол сэтгүүлчдийг өмгөөлөх байгууллага биш, хашраадаг байгууллага ч биш. Энэ хоёрын тэнцвэрийг хангах, эрх зүйн чадамжийг дээшлүүлэх нь бидний өмнө тулгарсан зорилт болоод байна.

Хэвлэлийн Консул нь олон улсын практикт хамгийн дэлгэрсэн хэвлэлийн мэдээллийн харилцааны хариуцлагын тогтолцоо бөгөөд Скандинавын бүх орнууд, Герман болон Англо-Саксон ардчилалтай орнууд, түүнчлэн Энэтхэг, Чили, Израйль, Танзани, Эстони зэрэг орнуудад ажиллаж байна. Ерөнхийдөө хэвлэл мэдээллийн эздийн, сэтгүүлчдийн, олон нийтийн төлөөллөөс Хэвлэлийн Консул бүрдэж, хэвлэл мэдээллийн эсрэг гомдол шүүж, мөн хэвлэлийн эрх чөлөөг хамгаалдаг. Энэ нь өөрийн гаргасан шийдвэрээ нийтлүүлэх ганцхан зэвсэгтэй.

### **Хэвлэл мэдээллийн эрх, эрх чөлөөний тухай хуулинд Хэвлэлийн Консулын талаар заалт орох шаардлагатай юу?**

Өнөөдөр хэвлэлтэй холбоотой маргаанд шүүхийн шийдвэр гарч байгаа үндэслэл нь ШУА-ын Хэл шинжлэлийн хүрээлэнгийн шинжээчдийн багийн дүгнэлт болдог. Гэтэл Цагдаагийн хэрэг бүртгэх албаныхан өөрсдөө эдгээр шинжээчдийг сонгодог. Мөн шинжээчдийн дүгнэлт, шүүхийн шийдвэр хоорондоо зөрөх тохиолдол гарч, үүнээс болоод “шүүх хуулийн байгууллага эрх баригчдын ашиг сонирхолд үйлчилж байна” хэмээн хардах явдал үүсч байна. Үүний зэрэгцээ сэтгүүлчдийг хэвлэл мэдээлэлд хаалттай шүүдэг нь хардахаас аргагүй байдалд оруулдаг.

Харин сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллага болох Хэвлэлийн Консулын дүгнэлт шинжээчийн мэдлэгтэй хараат бус байгууллагын хувьд шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болж болох юм.

Хэвлэлийн Консул нь сэтгүүлчдийн нэг нь нөгөөгөө шүүх, хариуцлага тооцох төдий биш, сэтгүүл зүйн ёс зүйн хэм хэмжээг, мэргэжлийн нэр хүндийг өндөрт өргөж, олон нийтэд гомдол мэдүүлэх боломж олгож, хэвлэн нийтэлснийхээ төлөө эрүүгийн хариуцлага хүлээдгийг болиулах үүрэгтэй гэж үзэж байна.

Гадны Хэвлэлийн Консулуудын туршлагыг харж байхад маш олон асуултууд урган гарч ирж байлаа.

- Манай шинэ Хэвлэлийн Консул нь хэр зэрэг үр дүнтэй ажиллаж чадах вэ? Хэвлэлийн Консул Хэвлэл мэдээллийн эсрэг үүсэх эрүүгийн болон иргэний захиргааны хэргийн тоог цөөлөх үү?



- Сонин хэвлэлийн мэдээллийн чанар ёс зүйн хэм хэмжээг өргөж чадах уу?
- Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд Хэвлэлийн Консулаас өөрсдөд нь өгсөн “чанарын тэмдэг”-ийг ашиглан олон нийтийн итгэлийг олж авч өөрийн сонины борлуулалтаа нэмэх, сурталчилгаа татахдаа ашиглаж болох уу?
- Улстөрчид хэвлэл мэдээллийн ёс зүйн хэм хэмжээг өргөх хэрэгсэл гэж үзэж байна уу?
- Хэвлэлийн Консул нь өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахаар ашигтай ажиллах бизнес биш. Шинэ Хэвлэлийн Консулыг гадаадын олон улсын тусламжийн байгууллагууд санхүүжүүлэх үү?
- Эсвэл хэвлэл мэдээллийн байгууллага, ТВ сонины эзэд Хэвлэлийн Консулыг санхүүжүүлэхэд хандив өгөх үү? Санхүүжилт нь нэг тоотой жигд хандив уу, эсвэл ТВ үзэгч, сонины захиалагчдын олон цөөн, төрөл зүйлээс хамаарч хэлбэлзэх үү? “Бусад нь төлөхгүй байхад би ч бас төлөхгүй” гэсэн барьцах хандлага үүсвэл яах вэ? Хэрэгтэй гэдгийг ойлгож төлөхөд бэлэн үү?
- Төрөөс Хэвлэлийн Консулын санхүүжилтэнд дэмжлэг авах хэрэгтэй юу? Авснаар Хэвлэлийн Консул улстөрчдөөс хамааралтай болох юм биш биз?
- Шүүх Хэвлэлийн Консулын шийдвэрийг харгалзаж үздэг байх уу?
- Манай Хэвлэлийн Консул ямар төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хамаарах вэ?



## ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

### 2.1 ДАНИЙН ХЭВЛЭЛИЙН КОНСУЛ

#### Суурь мэдээлэл

5.4 сая хүнтэй Дани улс 31 сонин уншдаг. Үндэсний хэмжээнд 3 өдөр тутмын том сонин, 4 жижиг сонин гардгаас гадна 22 орон нутгийн сонин, 2 шар сонин хэвлэгддэг. Эдгээрийн зэрэгцээ 225 дүүргийн сонин долоо хоногт 5 сая ширхэг хэвлэгдэж үнэгүй тардаг нь Данийн нэг өвөрмөц онцлог юм. Ritzaus гэдэг ганцхан мэдээллийн агентлагтай. Олон нийтийн DR (Данийн нэвтрүүлгийн компани), TV2 гэсэн хоёр үндсэн ТВ-тэй. Бусад хувийн жижиг ТВ-үүд кабель болон хиймэл дагуулаар нэвтрүүлгээ дамжуулдаг. Viasat (MTG), SBS нь TV2 сувгийн гол өрсөлдөгчид. 2009 оноос аналог ТВ-ээс дижитал ТВ рүү шилжинэ. Сүүлийн жилүүдэд Данийн хэвлэл мэдээллийн бодлого гурван үндсэн асуудалд анхаарч ирсэн: ТВ болон радио дижитал нэвтрүүлэгт шилжих, олон нийтийн болон хувийн ТВ-үүдийн ялгаа, үндэсний хэвлэл мэдээллийн хууль нь Европын холбооны хууль эрх зүйтэй зөрчилдөх болсон зэрэг асуудал юм.<sup>19</sup>

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг үндэсний хэмжээнд гурван байгууллага захирдаг. Соёлын Яам электрон мэдээллийн хэрэгслийг ерөнхийд нь хариуцдаг боловч зохицуулалт болон удирдлагыг нь хараат бус зөвлөл болох Радио Телевизийн Хороо (RTB) хариуцдаг. Мэдээллийн технологитой холбоотой зөвшөөрлийг Шинжлэх ухаан, Технологи, Мэдээллийн яамны дэргэдэх Теле холбооны агентлаг (*Tele Communication Agency within The Ministry of Science, Technology and Innovation*) хариуцдаг. Харин сонин хэвлэл нь Үндсэн хуулийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх заалтуудаар зохицуулагддаг. Засгийн газраас сонин хэвлэлд НӨАТ-аас чөлөөлөх болон шуудангийн тараалтын үнийг хөнгөлөх хэлбэрээр жилдээ 160 сая еврогийн татаас өгдөг.

---

<sup>19</sup> [http://www.ejc.net/index.php/media\\_landscape/article/denmark/](http://www.ejc.net/index.php/media_landscape/article/denmark/)

## Хариуцлагын систем

Данид Радио Телевизийн хороо нь Радио Телевизийн хуулийг мөрдүүлэх үндсэн үүрэгтэй. Харин Хэвлэлийн Консул нь Данийн Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хуулинд үндэслэн, хэвлэл мэдээллийн байгууллагын талаар гаргасан гомдлыг авч хэлэлцдэг бие даасан хараат бус олон нийтийн шүүх юм.

2005 онд Jyllands-Postens сонины өглөөний дугаарт нийтлэгдсэн шог зургийн Мухаммедтай холбогдож Ойрхи Дорнод дахь Данийн ЭСЯ-д руу хийсэн дайралт, НҮБ, АНУ-ын Ерөнхийлөгчийн зүгээс хандсан зэмлэл зэргээс болж Дани улсад олон нийтийн дунд хэвлэлийн талаар ширүүн маргаан өрнөсөн боловч хариуцлагын системд ямар нэг байдлаар нөлөөлөөгүй.<sup>20</sup>

## Хэвлэлийн Консулын үүрэг

Хэвлэлийн Консул нь 1991 оны Хэвлэл Мэдээллийн хариуцлагын хуулийг мөрдүүлэх зорилттой байгуулагдсан.<sup>21</sup> Хэвлэлийн Консул олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын талаар гаргасан гомдлыг авч хэлэлцдэг бие даасан, хараат бус олон нийтийн шүүх юм.<sup>22</sup>

*Хэн Консулд гомдол гаргаж болох вэ?*

Хэвлэлээр буруутгагдсан хүмүүс, компани байгууллагууд, нийгэмлэгүүд хэрэв үүнээс хохирол хүлээсэн гэж үзвэл хэн ч Консулд хандаж болно.

*Ямар төрлийн мэдээллийн хэрэгслийн эсрэг өргөдөл өгч болох вэ?*

Данийн Хэвлэлийн Консул нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны талаарх бүх гомдлыг, мөн нэвтрүүлэг, интернэт-медиад хамаатай хэргийг шийдвэрлэдэг.<sup>23</sup> Үүнд:

- Сонин хэвлэл: өдөр тутмын сонин, долоо хоног тутмын сэтгүүл, орон нутгийн сонин, мэргэжлийн холбогдолтой сонин болон жилд хоёроос доошгүй удаа хэвлэгддэг үндэсний тогтмол хэвлэлүүд.
- DR, TV2 болон Дани улсад нэвтрүүлэг цацах эрх авсан бусад радио, телевизүүд.
- Хэвлэлийн Консулд бүртгэлтэй зарим электрон мэдээллийн систем багтана.

*Ямар төрлийн хэрэгт өргөдөл гаргаж болох вэ?*

Хэвлэлийн Консул хэвлэлийн ёс зүйн эсрэг хэвлэлийн хэргийг зохицуулдаг бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл заавал хариу залруулга нийтлэх үүрэгтэй.

<sup>20</sup> [http://www.ejc.net/index.php/media\\_landscape/article/denmark/](http://www.ejc.net/index.php/media_landscape/article/denmark/)

<sup>21</sup> Харилцах хаяг: Pressenaevnet, Gyldenløvesgade 11, 1600 København V. цахим шуудан: [sekr@pressenaevnet.dk](mailto:sekr@pressenaevnet.dk)

<sup>22</sup> <http://www.pressenaevnet.dk>

<sup>23</sup> Данийн Хэвлэлийн Консулын Нарийн бичгийн дарга Сонни Кристоферсени (Sonny Kristoffersen, Sekretariatschef) цахим шуудан 2007.06.29

### *Хэвлэлийн ёс зүй*

Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хуулийн дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нэвтрүүлсэн байдал болон агуулга нь хэвлэлийн ёс зүйн дагуу заавал батлагдсан байх ёстой. Энэ хуулинд Хэвлэлийн ёс зүйг тодорхойлоогүй боловч Хэвлэлийн ёс зүйн дүрмийг<sup>24</sup> "Хэвлэлийн ёс зүй" гэж ойлгодог. Ийм маягаар Хэвлэлийн Консул хэрэг тус бүрийн тохиолдол болгоныг авч үздэг.

### *Хариу залруулга гаргах*

Гомдол гаргагч мэдээллийн хэрэгслээр мэдээллийг залруулж зөв болгон засаж нэвтрүүлэх боломж олж авна. Дараах нөхцөлд залруулга гаргана:

- мэдээлэл алдаатай, үнэн баримттай бодиттой нийтлэгдээгүй бол
- мэдээлэл зарим хор хохирол учруулах шалтгаан болсон

Залруулга нь зөвхөн баримттай мэдээлэл агуулсан, хууль зөрчөөгүй байх ёстой

## **Байгууллагын бүтэц, зохион байгуулалт**

Хэвлэлийн Консул нь 8 гишүүнээс бүрдэнэ. Дарга болон дэд дарга нь хуульч хүмүүс байх ёстой бөгөөд Данийн Дээд Шүүхийн зөвлөмжөөр томилдог. Одоо энэ албан тушаалд Данийн Дээд Шүүхийн шүүгч Нельс Груббе ажиллаж байна.

Бусад 2 гишүүнийг Данийн Сэтгүүлчдийн Холбоо<sup>25</sup> томилж, 2 гишүүн нь хэвлэл радио телевизийн удирдлагуудаас томилогдож, мөн 2 гишүүн Данийн Насанд хүрэгчдийн Боловсролын Консулын зөвлөмжөөр олон нийтийн төлөөлөл болж томилогдоно.<sup>26</sup> Гишүүд нь дөрвөн жилийн хугацаанд томилогддог.<sup>27</sup> Консул хэрэг хэлэлцэж, шийдвэр гаргахад дарга, дэд дарга нараас гадна 3 гишүүн бүрдсэн байх ёстой. Консул дороо ажлын алба буюу Нарийн бичгийн дарга нарын газартай.

## **Санхүүжилтийн эх үүсвэр, дүрэм журам**

Хэвлэлийн Консул жилдээ 200 мянган еврогийн төсөвтэй.<sup>28</sup>

## **Өргөдөл шийдвэрлэх механизм**

Нэхэмжлэгч нь тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандаж гомдол гаргах, эсвэл шууд Хэвлэлийн Консулд хандаж болно.<sup>29</sup>

---

<sup>24</sup> 1992 онд үндэсний Сэтгүүлчдийн Эвлэл хүлээн зөвшөөрснөөр "Хэвлэлийн ёс зүйн дүрэм"-ийг үндэсний хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ гэж Данийн Парламент баталжээ.

<sup>25</sup> Journalisforbund

<sup>26</sup> Хэвлэлийн хариуцлагын тухай хууль. 41 дүгээр зүйл.

<sup>27</sup> Ibid. 41.2 дугаар зүйл.

<sup>28</sup> Alliance of Independent Press Councils of Europe and (AIPCE) болон presscouncils.org

<sup>29</sup> Данийн Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хуулийн 5 дугаар бүлэг. Хэвлэлийн ёс зүй. 34.2 дугаар зүйл

Нэхэмжлэгч гомдол гаргах шалтгаан болсон тухайн нийтлэл нийтлэгдсэнээс хойш 4 долоо хоногийн дотор өргөдлөө Консулд өгнө.

Заргалдагч өргөдлөө өгснөөс хойш 4 долоо хоногийн дотор Хэвлэлийн Консул шийдвэр гаргах ёстой.

*Хариу залруулга гаргах*

Залруулга гаргах хүсэлтийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн Эрхлэгчид бичгээр өгнө.

Гомдлыг материал нийтлэгдсэнээс 4 долоо хоногийн дотор залруулна.

Хэвлэлийн газар гомдол гаргагчийг залруулгыг бэлтгэж өгөхийг шаардаж болно.

Хэрэв тухайн хэвлэлийн байгууллага залруулгыг нийтлэхээс татгалзвал, эсвэл нийтэлсэн залруулга нь гүйцэд бус, дутмаг байвал татгалзсан хариулт авсанаас хойш 4 долоо хоногийн дотор, эсвэл залруулга нийтлэгдсэнээс хойш 4 долоо хоногийн дотор Хэвлэлийн Консулд хандаж гомдол гаргаж болно.<sup>30</sup>

*Хэвлэлийн Консул гомдлын дагуу юу хийж чадах вэ?*

Хэвлэлийн Консул ялын тогтоол баталж, нэхэмжлэгчид санхүүгийн нөхөн төлбөр гаргуулж чадахгүй.

Хэргийг Хэвлэлийн ёс зүйн дагуу авч үзээд өөрийн шүүмжлэлийг илэрхийлнэ. Консул олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрхлэгчид шууд хандаж заасан хэмжээнд залруулга нийтлэхийг тушаана.

## **Эрх зүй болон бусад асуудлууд**

Данийн Хэвлэлийн Консулын үйл ажиллагаа нь “Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хууль” болон “Хэвлэлийн ёс зүйн дүрэм”-ээр зохицуулагддаг.

“Хэвлэлийн ёс зүйн дүрэм”-ийг үндэсний хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ гэж 1992 онд Үндэсний Сэтгүүлчдийн Эвлэл хүлээн зөвшөөрснөөр Данийн Парламент ёсчлон баталжээ.

Энэ товчхон дүрэм нь:

- A. Зөв мэдээлэл
- B. Эсрэг нэвтрүүлгээс сайн хэвлэл
- C. Шүүхийг сурвалжлах нь  
гэсэн гурван бүлэг, 20 зүйлээс бүрдэж байна.

Харин Данийн Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хуулийг Данийн Хууль зүйн яам өргөн барьсанаар Парламент 1991 онд баталж, 1992, 1996, 2000 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Данийн Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хуульд Хэвлэлийн Консултай шууд холбоотой заалтууд дараах бүлэг зүйлүүдэд оржээ.<sup>31</sup>

<sup>30</sup> Данийн Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хуулийн 6-р зүйл. Залруулга

<sup>31</sup> <http://www.pressenaevnet.dk>

## **5 дугаар бүлэг. Хэвлэлийн ёс зүй:**

**34 дүгээр зүйл.** Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн нэвтрүүлэг нийтлэл, түүний утга агуулга нь хэвлэлийн ёс зүйн үүднээс батлагдсан байх

**34.2 дугаар зүйл.** Хэрэв 34.1 дүгээр зүйлийг зөрчсөн бол энэ талаарх гомдлыг тухайн хэвлэл мэдээллийн байгууллагад эсвэл шууд Данийн Хэвлэлийн Консулд гаргаж болно. Аль ч тохиолдолд гомдол гаргах хугацаа нь нийтлэл нийтлэгдсэнээс хойш 4 долоо хоног байна. Зарга мэдүүлэгч тухайн хэвлэлийн байгууллагын талаар гомдол гаргаснаас хойш 4 долоо хоногийн дотор Хэвлэлийн Консул шийдвэрээ гаргана.

**34.3 дугаар зүйл.** Энэ бүлгийн 1 дүгээр зүйлийг DR (Данийн Радио), TV2 болон TV2-ын бүс нутгийн нэвтрүүлгүүд зөрчсөн гомдол саналыг нэвтрүүлгийг нэвтрүүлснээс хойш 4 долоо хоногийн дотор мэдүүлнэ. Зарга мэдүүлэгч тухайн нэвтрүүлгийн талаар гомдол гаргаснаас хойш 4 долоо хоногийн дотор Хэвлэлийн Консул шийдвэрээ гаргана.

**35 дугаар зүйл.** Радио ба Телевизийн Нэвтрүүлгийн хуулийн зохицуулалт нь радио телевизээр нэвтрүүлсэн зар сурталчилгаа болон арилжааны рекламн агуулганд хамаарна.

## **6 дугаар бүлэг. Залруулга, хариу өгөх**

**36 дугаар зүйл.** Мэдээлэл маргашгүй үнэн гэдгээс бусад тохиолдолд, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн баримт нь хэн нэгэнд санхүүгийн болон бусад ноцтой хэмжээтэй хохирол учруулахаар бол хэвлэл мэдээлэл залруулах хүсэлтийг анхаарч үзнэ.

**36.2 дугаар зүйл.** Залруулга гаргах хүсэлтийг мэдээлэлд хамаатай хүн гаргахаас гадна хэрэв тэрээр нас барсан бол ойрын хамаатан нь гаргаж болно.

**36.3 дугаар зүйл.** Мэдээллийг няцаахыг хүссэн хүн тухайн баримт мэдээлэл нийтлэгдсэнээс хойш 4 долоо хоногийн дотор Эрхлэгчид залруулга хийх хүсэлтийг бичгээр гаргана.

**36.4 дүгээр зүйл.** Радио Телевизийн нэвтрүүлгийн хуулийн зохицуулалт радио телевизийн зар сурталчилгааны залруулга гаргахад хамаарна.

**37 дугаар зүйл.** Залруулгыг нийтлэх үүрэг Эрхлэгчид оногдоно.

**37.2 дугаар зүйл.** Залруулгын утга нь хууль зөрчөөгүй, зайлшгүй баримт бүхий чухал үндсэн мэдээллээр хязгаарлагдана.

**37.3 дугаар зүйл.** Хэвлэл мэдээлэл нь залруулга гаргахыг хүссэн хүнээс залруулгыг бэлтгэхийг шаардаж болно.

**39 дүгээр зүйл.** Залруулга нь үнэ төлбөргүй, хугацаа алдалгүй, ил тод нүдэнд үзэгдэхээр, нөхцөл байдалдаа зохицсон байдлаар нийтлэгдэнэ.

**39.2 дугаар зүйл.** Мэдээллийг цаашид үргэлжлүүлж нийтлэх тохиолдолд баримт мэдээллээр хязгаарласан Редакцийн өгүүлэл тайлбар хийнэ.

**40 дүгээр зүйл.** Залруулга хийхээс татгалзсан хариу авсан хүн татгалзсан хариулт авсанаас хойш 4 долоо хоногийн дотор, аль болох түргэн хугацаанд Хэвлэлийн Консулд гомдлоо бичгээр мэдүүлнэ.

**40.2 дугаар зүйл.** Дутуу залруулга гаргасан тухай гомдлыг Хэвлэлийн Консулд тухайн залруулга нийтлэгдсэнээс хойш 4 долоо хоногийн дотор өгнө.

## **7 дугаар бүлэг. Хэвлэлийн Консул**

**41 дүгээр зүйл.** Хэвлэлийн Консул нь Хууль зүйн Яамны сайдын томилсноор Дарга, дэд дарга болон бусад 6 гишүүнээс бүрдэнэ. Дарга болон дэд дарга хуульч хүмүүс байх ёстой бөгөөд Данийн Дээд Шүүхийн зөвлөмжөөр томилно. 2 гишүүнийг Данийн Сэтгүүлчдийн Холбоо (Journalisforbund) томилж, 2 гишүүн нь хэвлэл радио телевизийн удирдлагаас томилогдож, мөн 2 гишүүн Данийн Насанд хүрэгчдийн Боловсролын Консулын (Dansk Folkeoplysnings) зөвлөмжөөр олон нийтийн төлөөлөл болж томилогдоно.

**41.2 дугаар зүйл.** Гишүүд болон орлогчдод хуулийн ижил хэм хэмжээ үйлчлэх бөгөөд 4 жилийн хугацаатай томилно. Дахин томилж болно.

**42 дугаар зүйл.** Консултай холбоотой хэргээр шийдвэр гаргахад дарга, дэд дарга нараас гадна 3 гишүүн бүрдсэн байх бөгөөд Данийн Сэтгүүлчдийн Холбооноос томилогдсон нэг гишүүн, хэвлэл мэдээллийн удирдлагаас томилогдсон нэг гишүүн, олон нийтийн төлөөллөөс томилогдсон нэг гишүүнээс бүрдэнэ.

**43 дугаар зүйл.** Хэвлэлийн Консул дараахт хамаарах хэргийг шийдвэрлэнэ.

1. тухайн нийтлэл хэвлэлийн ёс зүй зөрчсөн бол. 34 дүгээр зүйл.
2. Энэ хуулийн 6 дугаар бүлгийн зүйл заалтуудад холбогдох бол, хэвлэл мэдээлэл утга агуулга, хэлбэр хэмжээ, байрлал зэргийг оролцуулан залруулгыг нийтлэх үүрэгтэй.

**43.2 дугаар зүйл.** Консулын дарга дараах тохиолдолд гомдол хүлээн авахаас татгалзана.

1. Энэ зүйлийн 1 дүгээр зүйлд заасан Консулын эрх хэмжээнээс хэтэрсэн нь тодорхой тохиолдолд, эсвэл гомдол нь илэрхий худлаа үндэслэлтэй бол
2. Гомдол гаргах эрхгүй хүн буюу нийтлэл нэвтрүүлэгтэй холбоогүй хүн гомдол гаргасан бол

**43.3 дугаар зүйл.** Консулын дарга энэ хуулийн 34 дүгээр зүйл ба 34.2, 34.3 дугаар зүйл, 40 дугаар зүйлд заасан гомдол нь хэрэв хугацаа хэтэрсэн байвал уг гомдлыг хүлээж авахгүй.

**44 дүгээр зүйл.** Хэвлэлийн Консулд гаргасан бүх гомдол нь бичгээр байна

**44.2 дугаар зүйл.** Хэрэв тухайн хэрэг анхаарал татсан ноцтой гэж үзвэл Хэвлэлийн Консул өөрөө хэрэг үүсгэж болно. Тэгснээр Консул гомдсон талыг барих болно. Гомдол гаргагч талын нэр зөвхөн зөвшөөрөл авсны үндсэн дээр дурдагдана.

**45 дугаар зүйл.** Хэвлэлийн Консул хэвлэл мэдээллийн байгууллагаас гаргасан гомдолтой холбогдсон албан ёсны мэдэгдэл бичгээр авах хүсэлт тавих бөгөөд хэргийг хянах хугацаанд холбогдогч талуудаас нэмэлт мэдээлэл авна.

**45.2 дугаар зүйл.** Хэвлэлийн Консул гомдолтой холбоотой нийтлэгдсэн хэвлэлийн хувь болон радио, телевизийн нэвтрүүлгийн бичсэн хальсыг шаардаж болно.

**46 дугаар зүйл.** Хэвлэлийн Консулд ирсэн хэргийг хойшлуулалгүй шалгана.

**46.2 дугаар зүйл.** Хэрэв хэвлэл мэдээллийн байгууллага Хэвлэлийн Консулын хүсэлтийг хүлээн авсанаас хойш 7 хоногийн дотор хариу өгөөгүй бол хэргийг тухайн боломжтой нөхцөлд үндэслэж хэлэлцэнэ.

**46.3 дугаар зүйл.** Хэвлэлийн Консул талуудыг аман хэлбэрээр зарлан хуралдуулж болно. Зарга мэдүүлэгч дээрх хуралд шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд Консул гомдлыг буцаах, эсвэл боломжтой нөхцөлд үндэслэж хэлэлцэнэ. Хэрэв өөрийнх нь талаар гомдол мэдүүлсэн хэвлэл мэдээллийн байгууллага хуралд ирээгүй тохиолдолд хэргийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

**47 дугаар зүйл.** Хэрэв Хэвлэлийн Консулын гишүүнтэй холбоотой хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг гомдол хэлэлцэх болон эсвэл тухайн хэргийг үнэнч шударгаар шийдвэрлэхэд эргэлзэх тохиолдолд тухайн Хэвлэлийн Консулын гишүүнийг хуралд оролцуулахгүй.

**48 дугаар зүйл.** Талууд харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Хэвлэлийн Консул олонхийн саналд үндэслэн шийдвэрээ гаргана. Санал тэнцсэн тохиолдолд Консулын даргын саналыг харгалзана. Хэрэв шийдвэртэй санал нийлэхгүй бол санал зөрсөн үзэл бодлыг шийдвэрт дурьдана.

**49 дүгээр зүйл.** Хэвлэлийн Консул нь гаргасан шийдвэрээ Консулын онцлон заасан хэлбэр хэмжээгээр, аль болох түргэн нийтлэхийг хариуцагч болох олон нийтийн мэдээллийн хэрэгслийн Эрхлэгчид тушаана. Энэхүү нийтлэл нь ямар нэгэн нэмэлт тайлбаргүй, шаардсан ёсоор мэдэгдэхүйц байдлаар нийтлэгдэнэ.



**50 дугаар зүйл.** Хэвлэлийн Консулын шийдвэрийг өөр ямар нэгэн захиргааны эрх мэдэлтэн хянаж үзэх ёсгүй.

**51 дүгээр зүйл.** Хэвлэлийн Консул үйл ажиллагааныхаа жил бүрийн тайланг Хууль зүйн Яамны сайдад гаргаж өгнө. Олон нийтэд ил тод тайлагнана.

**52 дугаар зүйл.** Хэвлэлийн Консултай хэлэлцээ хийсний дараа Хууль зүйн Яамны сайд Хэвлэлийн Консулын үйл ажиллагааны журмыг батална.

**52.2 дугаар зүйл.** Консул нь нарийн бичгийн дарга нарын газартай байна.

**52.3 дугаар зүйл.** Хууль зүйн сайд Хэвлэлийн Консулын үйл ажиллагаанд хамаарах зардлын тогтсон хэмжээтэй төлбөрийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл төлөхөөр тушааж болно.

### *Түүхэн хөгжил*

1960 онд Данийн Сонины Эздийн Холбоо “Хэвлэлийн ёс зүй ба гэмт хэргийг сурвалжлах ёс зүйн” дүрмийг баталжээ. Энэхүү дүрэм нь гэмт хэргийг хэрхэн сурвалжлах, аваар осол, амиа хорлолттой холбоотой материал цуглуулах болон олшруулах зэргийг хэрхэн сурвалжлах дүрэм байлаа.

1964 онд Данийн Хэвлэлийн Консул байгуулагджээ. 1960 онд Данийн Сонины Эздийн Холбооноос баталсан дүрмийг сахиулахаар 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдав. Консулын дарга хуульч, бусад 3 гишүүнийг Данийн Сонины Эздийн Холбоо томилдог байлаа. 1968 онд бүрэлдэхүүн өргөсч, үүний зэрэгцээ ёс зүйн дүрэм зөвхөн гэмт хэрэг, хуулийн үйл ажиллагааг төдийгүй бусад хүрээг хамрах болжээ.

1974 онд дүрмийг шинэчлэн баталж, Хэвлэлийн Консулын хороо нь Дээд шүүх, Данийн Сонины Эздийн Холбоо, Данийн Сэтгүүлчдийн Эвлэл, Данийн Радиогийн төлөөлөөс бүрдэх болжээ. Учир нь Данийн Сэтгүүлчдийн Холбоо “энэ нь үг хэлэх, мэдээлэл цуглуулах, мэдээлэл болон мэдээг хэвлэн нийтлэх эрх чөлөөний хамгаалагч”, ёс зүйн дүрэм нь сэтгүүлчдийг шударга үнэний чиг гэж үзжээ. Консул 6 гишүүнээс бүрдэх болж, нэг гишүүнийг Дээд шүүх, нэг гишүүнийг Данийн Сонины Эздийн Холбоо, нэг гишүүн Данийн Радиоогоос, хоёр гишүүнийг Данийн Сэтгүүлчдийн Эвлэл, нэг олон нийтийн төлөөлөгчийг Данийн Парламентын Омбудсман томилдог болжээ.

1986 онд Хэвлэлийн Консул, Радио Консул, Үнэн зөв байдлын Зөвлөлийн оронд Хэвлэл Мэдээллийн Хариуцлагын Хороо байгуулагдлаа. Хороо нь Дээд шүүх, Данийн Мэргэжлийн Хэвлэлийн Ассоциаци, Данийн Сэтгүүл Эрхлэгчдийн Холбоо, Данийн Эзэн Хааны шуудангийн Ерөнхий захирал, Данийн Сэтгүүлчдийн Холбоо, Данийн Радио, ТВ2, Данийн Хуулийн Нийгэмлэг, Хууль Зүйн Яам, Ерөнхий сайдын офис зэрэг байгууллагуудын төлөөлөөс бүрдэх болжээ.

1992 онд Данийн Хэвлэлийн Консул томилогдлоо. Мөн Хэвлэлийн Хариуцлагын тухай хууль хэрэгжиж эхэлсэн.

## 2.2 ИХ БРИТАНИЙН ХЭВЛЭЛИЙН КОНСУЛ<sup>32</sup>

### Суурь мэдээлэл

Их Британийн Нэгдсэн Вант Улсын хэвлэл мэдээлэл хэмжээгээрээ дэлхийд хоёрдугаарт АНУ-ын дараа орохоор том, ярвигтай бүтэцтэй боловч сайтар боловсорсон системтэй билээ. Энэхүү глобальчлагдсан хэвлэл мэдээллийн нээлттэй зах зээл дээр BBC, Reuters-ийг эс тооцвол хэвлэлийн эзэнт гүрэн байдаггүй, Засгийн газрын deregulation буюу зохицуулалтгүй байх бодлогын<sup>33</sup> үр дүнд NewsCorp, Bertelsmann болон Time Warner зэрэг үндэстэн дамнасан корпорациуд үйл ажиллагаагаа идэвхтэй явуулдаг.

Хэвлэл мэдээллийг “бүтээлч үйлдвэрлэлийн салбар” гэж үзэж хэвлэл мэдээллийн бүх салбарт гадаадын улс орнууд оролцож болдог нь “хэвлэл мэдээллийн чанар унаж байгаа” тухай асуудал дагуулдаг. 47.5 сая насанд хүрсэн хүн амтай Их Британид 10 өдөр тутмын сонинтой. Эдгээр нь өдөр бүр 11.25 сая ширхэг хэвлэгддэг. 10 төрлийн Ням гарагийн сонин 12 сая ширхэг хэвлэгддэг. Сонин хэвлэлийг дотор нь “чанартай”, “дундаж зах зээлийн”, “шар сонин”<sup>34</sup> гэж гурав ангилдаг. Радио телевизийн хувьд олон нийтийн нэвтрүүлгийн BBC компани тэргүүлэх байр суурь эзэлдэг. BBC телевизийн 14 сувагтай, радио өргөн нэвтрүүлэг цацдаг. Их Британийн гэр бүлийн 70 хувь нь олон сувгийн ТВ-тэй бөгөөд 400 орчим суваг гардаг. NewsCorp корпорацийн хяналтанд байдаг BSkyB телевизийн хиймэл дагуулын ТВ-г 8 сая айл тавиулжээ. Дижитал ТВ-д 17 сая айл гэртээ холбуулжээ. 2008 оноос аналог ТВ-ийн долгионыг салгаж эхлэх бөгөөд 2012 он гэхэд нэг ч аналог ТВ-гүй болох юм. BBC 5 үндэсний радио, 30 орон нутгийн радиотой. Үүнтэй зэрэгцэн 300 орчим арилжааны радио станц Freeview, DAB, кабель, хиймэл дагуул, гар утас болон интернэт зэрэг бүх хэлбэрээр нэвтрүүлгээ цацдаг. 2014 он гэхэд аналог радио долгионыг бүрэн зогсооно. Энд дэлхийн бүх мэдээллийн агентлаг ажилладаг. Английн хэвлэлд мэдээ нийлүүлдэг 100 орчим орон нутгийн мэдээллийн агентлаг бий. 2010 он гэхэд Их Британийн бүх айлыг интернэтэд холбох Засгийн газрын бодлого хэрэгжиж байна.

Засгийн газрын хоёр хэлтэс болох Соёл, Хэвлэл мэдээлэл болон Спортын хэлтэс, Худалдаа Үйлдвэрлэлийн хэлтэс хэвлэлийн асуудлыг бүхэлд нь хариуцдаг. Олон нийтийн мэдээллийн албаны ирээдүй болон арилжааны хэвлэл мэдээллийн өсөлт энэ салбарын гол маргаантай асуудал болж байна. Хэвлэл мэдээллийг зохицуулж тус тусдаа ажиллаж байсан таван байгууллагыг 2003 оноос нэгтгэж Нэвтрүүлэг цахилгаан холбооны цагдаа (Ofcom to police broadcasting and telecommunications) байгуулснаар зохицуулалт ойлгомжтой оновчтой болсон.<sup>35</sup>

Хэвлэл мэдээллийн гол асуудал нь үндэсний хэвлэл мэдээллийн байгууллагыг гадаадын корпорациудын түрэлтээс хамгаалах, BBC-г 2016 оноос олон нийтийн хэвээр байлгах уу, арилжааны болгох уу гэдэг асуулт билээ.

<sup>32</sup> Press Complaints Commission: Вэбсайт нь [www.pcc.org.uk](http://www.pcc.org.uk)

<sup>33</sup> 1979-1997 он хүртэл Консерватив нам эрх барьж байх үед явуулж байсан энэ бодлого 1997 оноос хойш Тони Блэйрийн Хөдөлмөрийн намын засаглалын үед үргэлжлүүлж байгаа юм.

<sup>34</sup> red-top tabloid

<sup>35</sup> [http://www.ejc.net/index.php/media\\_landscape/article/united\\_kingdom/](http://www.ejc.net/index.php/media_landscape/article/united_kingdom/)

## Хариуцлагын систем

Тус улсын хэвлэл мэдээллийн тогтолцоонд сайн дурын болон хууль зүйн хариуцлагын систем зэрэгцэн оршдог. Хэвлэл мэдээлэлтэй холбоотой 140 орчим хууль тогтоомж байдгаас гомдол гаргах нь хэвлэлтэй тооцоо бодох сайн хэрэгсэл болдог. Их Британийн хуулиар хувийн нууцыг хамгаалдаггүй байсан ч нууц зөрчсөн тухай хэрэг гарч байв. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө Европын Хүний Эрхийн Конвенцийн дагуу Их Британид 1998 оны Хүний Эрхийн Хуулиар хамгаалагдсан. Энэ хуулинд хувийн нууцыг хууль ёсны болохыг тунхагласан юм. 2005 оноос Мэдээллийн Эрх чөлөөний тухай хууль хэрэгжиж эхэлсэн.

Хэвлэл мэдээллийн “хоточ нохойн” үүргийг MediaWise Trust (ёс зүй); Campaign for Press and Broadcasting Freedom; Campaign for Freedom of Information; the Runnymede Trust, the London International Research Exchange байгууллагууд хариуцдаг.

## Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комисс

Их Британийн Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комисс (PCC) буюу Хэвлэлийн Консул нь олон нийтийн гишүүдийн зүгээс сонин сэтгүүлийн нийтлэлийн талаарх гомдлыг хэлэлцдэг бие даасан хараат бус байгууллага юм.<sup>36</sup>

“Олон нийтэд хүргэх манай үйлчилгээ үнэгүй, хурдан, хялбар” гэж Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комисс мэдэгддэг. Ихэнх гомдлыг нэхэмжлэгч талаас ямар нэгэн төлбөргүйгээр ажлын 28 хоногийн дотор шийддэг байна.

2006 онд Комисс нь 3325 гомдол хүлээн авчээ. Гомдлыг Мэргэжлийн ёс зүйн дүрмийн<sup>37</sup> дагуу шалгаж шийдвэрлэснээс нийт гомдлын гуравны хоёр нь сурвалжлагын алдаа, тавны нэг нь ямар нэг байдлаар хувийн нууцтай холбоотой гарчээ. Эрхлэгч нар өөрсдөө зохиосон Сонины эрхлэгч нарын Мэргэжлийн ёс зүйн дүрмийг нь бүх үндэсний болон бүс нутгийн сонин, сэтгүүл нэгдэж мөрддөг. Дүрэмд ямар мэдээг хэрхэн цуглуулах, мэдээлэх талаар төдийгүй хүүхэд, эмнэлгийн өвчтөн, ялгаварлан үзэгдэж болзошгүй бусад хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлгүүдийг хамгаалах талаар тусгасан байдаг.<sup>38</sup>

Комиссын үндсэн зорилго нь Мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тухай ямар ч гомдлыг аль болох хурдан, эерэгээр шийдэх явдал юм. Үүний нэг амжилт нь 2006 онд 31 гомдолд л шийтгэл оногдуулсан байна. Энэ нь өөрийн зохицуулалтын сул тал биш харин ч хүч давуу тал гэж үзжээ.

Комисс гомдол шийдвэрлэхийн зэрэгцээ олон нийтийн зүгээс энэ албаны талаар болон Мэргэжлийн ёс зүйн дүрмийн талаар асуусан утасны дуудлаганд хариулдаг. 2006 онд Комисс 8550 орчим утасны дуудлага, факс, цахим шуудан хүлээн авчээ. Энэ нь Комисс болон олон нийтийн харилцааг ойртуулж холбож байдаг юм.

<sup>36</sup> Харилцах хаяг: The Press Complaints Commission, Halton House, 20/23 Holborn, London, EC 1N 2JD цахим шуудан: [complaints@pcc.org.uk](mailto:complaints@pcc.org.uk)

<sup>37</sup> Code of Practice буюу Мэргэжлийн ёс зүйн дүрэм 2006 оны 8 дугаар сард PCC баталсан бөгөөд сонин хэвлэлийн салбарт үйлчилдэг.

<sup>38</sup> <http://www.pcc.org.uk/cop/practice.html>

Английн хараат бус өөрийн зохицуулалтын систем нь ямар ч хууль эрх зүйн хяналтаас илүү үр дүнтэй байгааг харуулж байна. Гомдол шийдвэрлэгдэхгүй удаахрах, сунжирсан урт хууль шүүхийн зарга болдог хуулийн хяналт нь олон нийтийн төлөөллийн хувьд ашиггүй юм. Харин Английн өөрийн зохицуулалтын систем болох Хэвлэлийн Консул нь хурдан болоод үнэгүй ажээ.

Үнэгүй учраас Комисст гомдол гаргагч нь өмгөөлөгч болон өөрийгөө төлөөлөх хэн нэгнийг мөнгө төлөн хөлслөх шаардлагагүй, татвар төлөгчдийн хувьд шүүхэд зориулж нэмэлт зардал гаргахгүй таатай юм.

## Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комисс нь:

- Комиссын гишүүд
- Комиссын Нарийн бичгийн дарга нарын газар
  - Албан тушаалд томилох комисс
  - Ёс зүйн хороо
  - Санхүүгийн Хэвлэлийн Стандартын Зөвлөл буюу Pressbof
  - The Charter Compliance Panel
  - О нийттэй хийсэн гэрээг мөрдүүлэх комисс гэсэн бүтэцтэй. Таван дэд комисс тус тусдаа үүрэгтэй.

### Комисс

Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комисс 17 гишүүнтэй. Сонин хэвлэлийн салбараас хараат бус байх үүднээс тэдний ихэнх нь хэвлэл мэдээлэлтэй холбоогүй хүмүүс байдаг. Гишүүдийг:

- Комиссын дарга,
- олон нийтийн төлөөлөл,
- хэвлэлийн төлөөлөл гэж гурав ангилдаг.

Бие даасан хараат бус Комиссын даргыг сонин хэвлэлийн салбараас томилдог. Комиссын даргын ажлаас өөрөөр сонин хэвлэлтэй холбоотой байх ёсгүй. Одоогийн даргыг Христوفر Майэр гэдэг хашир дипломат гүйцэтгэдэг.<sup>39</sup>

Олон нийтийн төлөөлөл болон Хэвлэлийн төлөөллийг хараат бус Албан тушаалд томилох комисс томилно. Олон нийтийг төлөөлсөн гишүүд нь сонин сэтгүүл, хэвлэлийн бизнестэй ямар ч холбогдолгүй, харин хэвлэлийг төлөөлсөн гишүүд нь сонины туршлагатай эрхлэгч редактор байх ёстой.

Комисс нь Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комиссын хүлээн авсан бүх гомдолд эцсийн шийдвэрийг гаргана. Комиссын гишүүд нь Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комиссын захирлуудын үүрэг гүйцэтгэж, Комиссын менежментэд хариуцлага хүлээнэ.

---

<sup>39</sup> Гүн Христوفر Майэр 2003 оны 3 дугаар сараас өнөөг хүртэл Комиссын дарга хийж байгаа. Хуучин дипломатч. АНУ, ХБНГУ-д Элчин сайд хийж байсан. 1994-1996 онд Ерөнхий сайдын Хэвлэлийн төлөөлөгч байсан.

### *Комиссын Нарийн бичгийн дарга нарын газар*

Комиссын Нарийн бичгийн дарга нарын газар нь Комиссын өдөр тутмын ажлыг гүйцэтгэнэ. Ирсэн бүх гомдлыг шалгахгаас эхлээд хариуцагч болон гомдол гаргагч талыг холбож, эвлэрүүлэх арга хэмжээ авна. Комиссын Нарийн бичгийн дарга нарын газар 14 ажилтантай. Тэдний хэн нь ч сэтгүүлч биш байна. Энэ нь хэвлэлийг зохицуулахаар хариуцсан Комисс хэвлэлээс хараат бус байх баталгаа болдог.

### *Албан тушаалд томилох комисс*

Таван дэд комиссын нэг энэ комисс нь 5 гишүүнтэй. Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комиссын дарга, Санхүүгийн Хэвлэлийн Стандартын Зөвлөлийн дарга болон бусад гурван гишүүнээс бүрдэж, Хэвлэлийн Гомдол хүлээн авах Комисст шинээр гишүүн сонгож, The Charter Compliance Panel, О нийттэй хийсэн гэрээг мөрдүүлэх комисст шинэ гишүүн томилно.

### *Ёс зүйн хороо*

Мэргэжлийн Ёс зүйн дүрмийг эрхлэгч нараас бүрдсэн Ёс зүйн хороо тогтмол эргэн хянаж байдаг. Энэ бүтэц нь олон нийтийн санаа бодол болон Парламентын зөвлөмж, Хэвлэлийн Комиссын өөрийн мэдээллийг үндэслэн технологийн хөгжлийг даган эрчимтэй өөрчлөгдөж байгаа хэвлэлийн салбарын шаардлагын дагуу Ёс зүйн дүрмийг шинэчилж байдаг. Ёс зүйн хороог Албан тушаалд томилох комисс сонгохдоо Их Британийн таван хэвлэлийн холбооны (Сонины Нийгэмлэг, Сонины Эздийн Холбоо, Шотландын Сонины Эздийн Холбоо, Шотландын Өдөр тутмын сонины холбоо, Тогтмол хэвлэл эрхлэгчдийн холбоо) саналыг харгалзан үздэг.

## **Санхүүжилтийн эх үүсвэр**

Их Британийн Хэвлэлийн Консул нь сонин хэвлэл болон сэтгүүлийн салбараас санхүүждэг боловч хараат бус байдаг. Консул нь төрөөс санхүүждэггүй.

Хэвлэлийн өөрийн зохицуулалтын бүтэц болох Санхүүгийн Хэвлэлийн Стандартын Зөвлөл буюу PressBof нь хэвлэл сэтгүүлийн салбарын татвараар Хэвлэлийн Гомдол Хүлээн авах Комиссыг санхүүжүүлэхийн тулд 1974 онд байгуулагдсан. Ингэснээр хэвлэлээс төгс хараат бус бие даан ажилладаг.

Комиссын 2005 оны санхүүгийн жилийн тайланг *Deloitte and Touche* аудитаар шалгуулжээ. Үүнийг жишээ болгон доор үзүүлээ:

## Зардал (фунт стерлингээр)<sup>40</sup>

Цалин хөлс, холбогдох зардлууд	927,208
Түрээс, техникийн үйлчилгээ	107,921
Хууль зүйн мэргэжлийн төлбөр	172,460
Томилолтын зардал, баяр, пиар	155,234
Утас, бичгийн хэрэгсэл, даатгал, хэвлэл болон бусад офисийн зардлууд	105,422
Элэгдэл хорогдол	19,720
Бусад зардал	84,482
Вэбсайт	24,486
Банкны шимтгэл	1,377
Charter Commissioner/ Charter Compliance Panel	38,399
1 Salisbury Square-ийн сүйрэл	46,083
<b>Бүгд</b>	<b>1,682,792</b>

## Мэргэжлийн ёс зүйн дүрэм

Гомдол Хүлээн авах Комиссын удирддаг хэвлэлийн өөрийн зохицуулалтын тулгын чулуу нь Мэргэжлийн Ёс зүйн дүрэм юм.

Энэхүү дүрэм нь хоёр талтай. Нэг талаар хэвлэлийн салбарыг хөтөлж удирдах тогтолцооны зарчмуудыг бүрдүүлж байдаг. Нөгөөтэйгүүр Комисст олон нийтийн гишүүдийн зүгээс ирсэн гомдлыг ямар хүрээнд, хэрхэн шийдвэрлэх тухай хувиршгүй тодорхой зааг хязгаарыг өгч байдаг юм.

Мэргэжлийн Ёс зүйн дүрэм нь хэвлэлийн салбарын өөрийнх нь шийдвэрлэх дүрэм юм. “Энэхүү дүрэм нь зөвхөн үг үсэг төдий биш зоригжуулагч цог заль юм” гэж удиртгалд өгүүлжээ.<sup>41</sup> Энэ нь хараат бус Комиссоор батлагдаж, ажил хэрэг болдог ч үнэндээ хэвлэлийн салбарын өөрийн төсөл учраас өөрийн зохицуулалт болон Комиссын үүрэг даалгаврыг сонин хэвлэл, сэтгүүлийн салбар хүлээн зөвшөөрөх баталгаа болдог. Үүн дээр нэмэхэд, сэтгүүлч эрхлэгч нарын ажил олгогчтой хийх хөдөлмөрийн гэрээнд өөрийн зохицуулалтыг харгалзан үздэг.

Мэргэжлийн Ёс зүйн дүрэм Ёс зүйн хороогоор тогтмол хугацаанд эргэн хянагдаж байдаг. Тиймээс цаг үетэйгээ зохицож хурдан өөрчлөгдөж, байнга тогтмол шинэчлэгдэж чаддаг.

Гомдол Хүлээн авах Комисс Мэргэжлийн ёс зүйн дүрмийн эцсийн хариуцлагыг хүлээж, ямар нэгэн өөрчлөлт оруулах бол баталж зөвшөөрдөг.

<sup>40</sup> Press Complaints Commission Annual Review 2006

<sup>41</sup> NEWSPAPER AND MAGAZINE PUBLISHING IN THE U.K. Editors' Code of Practice. 2006

Одоогийн дүрмийг 2006 оны 8 дугаар сард гомдол Хүлээн авах Комисс баталснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хэвлэлийн бүх гишүүд нь мэргэжлийн түвшинг хамгийн өндөрт өргөх үүрэгтэй. Энэхүү дүрэм нь хувь хүний эрх болон олон нийтийн мэдэх эрх аль алиныг хамгаалах ёс зүйн стандарт юм. Энэ нь өөрийн зохицуулалтын системийн үндсэн суурь болж хэвлэлийн салбарыг нэгтгэж байгаа юм.

## МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Дүрэм 16 бүлэгтэй<sup>42</sup>. Бүлэг тус бүрээр задлавал:

### 1. Нямбай байдал

1. Хэвлэл нь нямбай бус, төөрөгдүүлж хуурсан, эсвэл гуйвуулж мушгисан мэдээлэл, гэрэл зургийг нийтлэгдэхгүй байх талаар анхаарсан байна.
2. Нягтлаагүй, төөрөгдүүлсэн мэдээллийг залруулж засах ёстой бөгөөд зохих уучлалт хэвлүүлнэ.
3. Хэвлэл нь баримт, таамаглал, тайлбар зэргийг тодорхой ялгаж салгах зарчим баримтална.
4. Үйл ажиллагааны үр дүнд гүжирдэхгүйн тулд хэвлэл үнэн зөв, нягт нямбай мэдээлэх ёстой, үгүй бол өөр аргаар тохирч зохицуулах, тохиролцсон мэдэгдлийг нийтэлнэ.

### 2. Залруулах боломж олгох

Үндэслэлтэй бол нягтлаагүй мэдээллийг шударгаар залруулах боломж олгоно.

### 3. Хувийн нууц

1. Бүх хэвлэлийнхэн хүний хувийн болон гэр бүлийн амьдрал, гэр орон, эрүүл мэнд, захидал харилцаа, болон дижитал харилцааг хүндлэх ёстой. Эрхлэгч нар хувь хүний хувийн амьдралд зөвшөөрөлгүй халдахаас зайлсхийх
2. Тухайн хүний зөвшөөрөлгүйгээр хувийн эзэмшилд<sup>43</sup> авсан гэрэл зургийг нийтлэхийг хориглоно.

### 4. Дарамтлах

1. Сэтгүүлчид айлгаж сүрдүүлэх, түгшээж зовоох, тогтмол мөшгих явдлыг хийх, хийхээр завдаж болохгүй.
2. Сэтгүүлчид тухайн хүнийг зогсоохыг шаардсанаас хойш тогтмол мөшгих, асуух, утасдах, гэрэл зураг авах, мөрдөх болон өөрийн эзэмшлээс гарахыг шаардсаны дараа эдлэнд үлдэж дагаж мөрдөх ёсгүй.
3. Эрхлэгч нар нь эдгээр зарчмуудыг өөрийн ажиллагсдаа тайлбарлан мөрдүүлж, бусад эх сурвалжаас баталгаагүй материал авахгүй байх талаар анхаарах ёстой.

<sup>42</sup> AND MAGAZINE PUBLISHING IN THE U.K. Editors' Code of Practice. 2006

<sup>43</sup> Хувийн эзэмшил гэдэг нь хувийн нууц байж болох үндэслэлтэй хувийн болон олон нийтийн хөрөнгө байгууламж болно. NEWSPAPER AND MAGAZINE PUBLISHING IN THE U.K. Editors' Code of Practice. 2006

5. Уй гашуу болон цочролд халдах

1. Хувь хүний уй гашуу, цохилт цочролтой холбоотой хэрэгт асууж байцаахдаа өрөвдөж хайрласан, болгоомжтой байдлаар мэдрэмжтэй хандана. Энэ нь хууль зүйн үйл ажиллагаа, мөрдөн байцаалтыг мэдээлэх эрхийг хязгаарлахгүй.
2. Амиа хорлосон тухай мэдээлэхдээ хэрхэн хорлосон талаар нарийвчилсан сурвалжлагаас зайлсхийнэ.

6. Хүүхэд

1. Сургууль дээрээ байгаа хүүхэд залуучуудыг зайлшгүй бус тохиолдолд сурвалжлахгүй.
2. Өөртэй нь болон бусад хүүхэдтэй холбоотойгоор 16 нас хүрээгүй хүүхдүүдтэй эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр ярилцлага хийх, гэрэл зураг авах ёсгүй.
3. Сургуулийн удирдлагын зөвшөөрөлгүйгээр сурагчдын гэрэл зургийг авч болохгүй.
4. Хүүхдийн төлөө гэдэг нь тодорхой биш бол насанд хүрээгүй багачуудад мөнгө төлж хүүхэдтэй холбоотой мэдээлэл цуглуулах ёсгүй. Энэ нь эцэг эх болон асран хүмүүжүүлэгч нарт мөнгө төлж тэдний хүүхэд, асрамжинд байгаа хүүхдийн талаарх мэдээлэл авахад хамаарна.
5. Эрхлэгч нар эцэг эх, асран хүмүүжүүлэгчийн алдар нэр, албан тушаал зэргийг дурдаж хүүхдийн хувийн амьдралын нарийн ширийнийг мэдээлэлд хэрэглэх ёсгүй.

7. Хүүхэд секстэй холбогдсон хэрэг

1. Хуулиар хориглоогүй зөвшөөрсөн байлаа ч 16 нас хүрээгүй хүүхдүүдийг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болон гэрч болсон тохиолдолд таниулж нэрлэхгүй.
2. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл оролцсон мэдээллийг сурвалжлахдаа:
  - a. Хүүхдийг нэрлэхгүй, танигдахаар тодорхойлохгүй
  - b. Насанд хүрсэн этгээдийг нэрлэж болно
  - c. Хохирогч хүүхдийг таньж болохоор мэдээлсэн бол "өдөх" гэдэг үгийг хэрэглэхгүй.
  - d. Хэрэгтэн болон хүүхдийн холбооны талаар битүү үгээр хэлж цухуйлгахгүй

8. Эмнэлэгт

1. Эмнэлэг болон бусад адил төстэй хүрээлэнгийн олон нийтэд зориулаагүй хэсэгт нэвтрэхээсээ өмнө удирдлагад нь өөрийгөө танилцуулж зөвшөөрөл авах ёстой.
2. Хувийн нууцад халдахтай холбоотой зарчим, заалт нь эмнэлэг болон ижил төстэй хүрээлэнд буй хүмүүсийн хувьд ч адил үйлчилнэ.

9. Гэмт хэргийг сурвалжлах нь

1. Тухайн гэмт хэрэгтэй холбоотой биш л бол гэмт хэргийн хэрэгтэн болон сэжигтний найз нөхөд, хамаатан садангийн талаар тэдний зөвшөөрөлгүй нэрлэж заахгүй.
2. Гэмт хэргийн гэрч эсвэл хохирогч бослон хүүхдийн эмзэг байр суурийг харгалзан анхаарч үзнэ.



*10. Нууц техник төхөөрөмж болон дүрээ хувиргах*

1. Хэвлэл нууц дуран камер болон нууцаар чагнах төхөөрөмж хэрэглэж, эсвэл гэрийн болон гар утасны яриаг чагнасан, мессэж ба цахим шуудан, эзэнгүй баримт гэрэл зураг ашигласан мэдээлэл хайх ёсгүй.
2. Өөр бусад аргаар мэдээлэл авах боломжгүй үед дүрээ хувиргах, нэрээ сольж мэдээлэл олох нь зөвхөн олон нийтийн эрх ашиг сонирхлын төлөө тохиолдолд зөвшөөрнө.

*11. Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой аллагын хохирогчид*

1. Хэвлэл нь бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой аллагын хохирогчдыг нэрлэж тодорхойлохгүй. Хуулийн дагуу нөхцөл байдлыг зөвтгөж болохоос бусад тохиолдолд хохирогчийг тодорхойлсон танигдаж болохоор материал нийтлэхгүй.

*12. Ялгаварлан гадуурхах*

2. Хэвлэл тухайн хүний гарал, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, бэлгийн ориентаци, эсвэл бие физиологийн эсвэл мэдрэлийн өвчин, хөгжлийн бэрхшээлтэйг үл тоомсорлож, хортойгоор зааж дуудаж болохгүй.
3. Тухайн нийтлэлд хамаагүй л бол бие хүний гарал угсаа, арьсны өнгө, шашин, бэлгийн ориентаци, физиологийн эсвэл мэдрэлийн өвчин, хөгжлийн бэрхшээлийн талаар дурдахгүй.

*13. Эдийн засгийн сэтгүүл зүй*

1. Хэдийгээр хуулиар хориглоогүй байсан ч сэтгүүлч давуу талаа ашиглан олж авсан санхүүгийн мэдээллийг өөртөө ашиг олоход ашиглахгүй. Ийм санхүүгийн мэдээллийг бусдад дамжуулахгүй.
2. Эрхлэгч ба эдийн засаг хариуцсан эрхлэгчид танилцуулалгүй өөрийн болон хамаатныхаа сонирхол оролцсон хувьцаа, үнэт цаасны талаар бичиж болохгүй.
3. Өөрийн сайхан бичсэн, ойрын үед бичих гэж байгаа хувьцаа үнэт цаасыг зарах эсвэл худалдаж авч болохгүй.

*14. Эх сурвалжаа нууцлах*

Сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжуудаа хамгаалах ёс зүйн үүрэгтэй.

*15. Шүүх ажиллагааны үеэр гэрчид төлөх*

*16. Гэмт хэрэгтэнд төлөх*

1. Тодорхой гэмт хэргийн тухай мэдээл цуглуулах явцад тодорхой сонирхолтой болгохын тулд түүх, гэрэл зураг, мэдээлэлд төлбөр төлж болно.
2. Эрхлэгчид төлбөрийг олон нийтийн ашиг сонирхолын тулд төлж байгааг баталж олон нийтийг уриална. Хэрэв олон нийтийн сонирхол илрээгүй бол төлбөр төлсөн байсан ч нийтлэхгүй.

## Өргөдөл шийдвэрлэх механизм

Гомдол Хүлээн авах Комисс нь 24 цагийн турш гомдол хүлээн авдаг. 2006 онд хамгийн олон гомдол хүлээн авсан бөгөөд 1996 оноос 400 хувиар олон гомдол авчээ.

Зөвхөн бүс нутгийн сонинд гэхэд 13000 сэтгүүлч ажилладаг бөгөөд үүн дээр үндэсний хэмжээнд гардаг сонин, сэтгүүл, чөлөөт сэтгүүлчид, гэрэл зурагчид нэмэгдэхээр хэдэн арван мянган хүн хэвлэлд ажиллаж, хэвлэлийн салбарын цар хэмжээ том байгаа нь Комиссын ажилд ихээхэн нөлөөлдөг байна.

Цаашид сонин төдийгүй аудио болон видео хэвлэл мэдээлэл, интернэт Мэргэжлийн ёс зүйн дүрэмд нэгдэж байгаа болохоор энэ цар хүрээ улам нэмэгдэх юм.

Комисст хичнээн олон гомдол ирнэ, тэр хэмжээгээр шүүхэд хандах явдал багасч байна.<sup>44</sup> 2006 онд хувийн нууцтай холбоотой 96 гомдол шийдвэрлэжээ.

Хэвлэлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн сонин, сэтгүүл, тухайн сэтгүүлчийн нийтлэл, зан авирын талаар гомдол гаргахаар шийдсэн бол тухайн хэвлэлийн эрхлэгчид нэн даруй алдаагаа залруулахыг шаардсан гомдол бичээд долоо хоногийн дотор хариу өгөхгүй бол Гомдол Хүлээн авах Комисст бичгээр болон онлайнгаар хандана.

Гомдлыг хаягласан нийтлэл гарсанаас хойш 2 сарын дотор гомдол мэдүүлэх боломжтой. Хэвлэлийн талаар гомдол гаргах талаараа Гомдол Хүлээн авах Комисст утсаар болон текстфоноор холбогдож нэмэлт мэдээлэл, туслалцаа авч болно.

Ихэнх гомдлыг нэхэмжлэгч талын ямар ч төлбөргүйгээр ажлын 25 хоногийн дотор шийддэг байна.

Гомдол Хүлээн авах Комисс Гомдол мэдүүлэгчтэй хийх гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхээр олон нийтийн өмнө гэрээнд дурдсанаар 8 үндсэн үүрэг хүлээдэг байна:

## ГОМДОЛ МЭДҮҮЛЭГЧТЭЙ ХИЙХ ГЭРЭЭ

- Дуудлаганд заавал хариу өгнө. Ажлын цагаар үйлчлүүлэгчийн дуудлага 4 дуугарахын дотор утсаа авах болно. Хэрэв захидал илгээсэн бол хүлээн авснаа танд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэнэ.
- Бид аль болох хурдан шийдэхийг хичээдэг бөгөөд дунджаар ажлын 35 хоногт таны гомдлыг барагдуулна. Хэрэв асуудал төвөгтэй болж цаг хугацаа шаардлагатай бол бид яагаад удах болсон шалтгаанаа тайлбарлах болно. Ажлын 15 хоног тутамд таны гомдол хэрхэн шийдэгдэж байгаа талаар мэдээлэх болно.
- Бид Мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөнөөс үүдсэн гомдлыг шийдвэрлэхийг хичээж тантай хамтран ажиллах болно.
- Манай үйл ажиллагаа тунгалаг тодорхой явагддаг: Комисс тухайн материалтай холбоотой талуудын танилцсан материалыг л авч хэлэлцдэг.
- Татвар төлөгч мөн ч бай, биш ч бай бид таны гомдлыг өртөг зардалгүй шийдвэрлэж өгнө.

---

<sup>44</sup> AND MAGAZINE PUBLISHING IN THE U.K. Editors' Code of Practice. 2006


- Бид бүхэнд хүртээмжтэй байхыг чармайдаг. Унаган эх хэл нь англи биш бол шаардлагатай тухайн хэлээр үйл ажиллагааг явуулдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тексфоноор болон аудио бичлэгээр харилцаж болно.
- Бидний үүд хаалга байнга нээлттэй. Таны гомдол бичих явцад манай ажилтнууд тусална. Харин гомдлыг хүлээн авсаны дараа гомдол хариуцсан ажилтан тантай үргэлжлэн харилцах болно. Манай ажилтнууд нэрээ хэлж, тантай эелдэг харилцана.
- Бид ёс зүйн хэм хэмжээг жилээс жилд дээшлүүлэхийг хичээдэг. Жил болгон хүлээн авсан ба шийдвэрлэсэн гомдлын статистик тоог, мөн гомдол шийдсэн дундаж хугацааг нийтэлдэг. Жилийн эцэст үйл ажиллагааныхаа тайланг хэвлэн нийтлүүлж, Мэргэжлийн стандартыг хэрхэн улам өргөх талаар Комисст зориулж зөвлөмж гаргадаг.

### Шийдвэрийг олон нийтэд мэдээлэх

Гомдол Хүлээн авах Комиссын шийдвэрийн дагуу тухайн хэвлэл нь залруулга, уучлал хүсэх болон бусад хэлбэрээр залруулга нийтэлнэ.

Залруулга болон уучлал гарсан хэлбэр хэмжээний талаар заримдаа маргаан гардаг. Зарим хүмүүс нийтлэгдсэн сурвалжлагатай яг адил хэмжээтэй, адилхан хэмжээтэй гарчиг шрифттэй нийтлэхийг шаарддаг. Харин энэ нь төвөгтэй байдаг. Залруулга нь тухайн нийтлэлийн зөвхөн нэг хэсэг бүлэгт, эсвэл текстэнд хэдхэн үгэнд агуулагдсан санаанд хамаатай байх явдал бий. Тиймээс Ёс зүйн дүрмийг хэр зэрэг зөрчсөнөөс хамаарч залруулгын байрлал болон хэмжээг тогтоодог.

2006 онд залруулга, уучлалыг нийтэлсэн байдал



## 2.3 НЕДЕРЛАНДЫН ХЭВЛЭЛИЙН КОНСУЛ

### Суурь мэдээлэл

16 сая хүн 34 мянгахан хавтгай дөрвөлжин км нутагт шахалдаж амьдардаг Голландад сонин уншдаг хүн олон, өдөрт 3.5 сая ширхэг өдөрт тутмын сонин уншдаг боловч сонин худалдан авах хүмүүсийн тоо зогсолтгүй буурч байна. Ялангуяа 2002 онд Голландын нэртэй улстөрч Пим Фортуины /Pim Fortuyn/ амийг бүх нийтийн сонгуулийн өмнө хөнөөсөн аллагаас хойш хэвлэлийн үүрэг ролийн асуудал хурцаар тавигдах болсон. Нөгөөтэйгүүр хэвлэлийн зах зээл эдийн засгийн дарамтанд орж эхэлсэн юм. Сонины зах зээлд хэвлэлийн гурван хэвлэн нийтлэгч нийт сонин зах зээлийн 90 хувийг эзэлдэг бөгөөд гадаадын хэвлэлийн компаниуд хүчтэй байна. Өдөр тутмын дөрвөн сонин “de Volkskrant”, “NRC Handelsblad”, “AD and Trouw” –г эрхлэн гаргадаг РСМ компанийн гол хөрөнгө оруулагч нь Их Британийн “АРАХ”, Амстердамд хэвлэгдэн гардаг “Het Parool”-ыг Бельгийн “Персгруп” эзэмшдэг бол өнгөрсөн жил 2006 онд Лимбургт гардаг хоёр сонинг Английн “Месом” авсан байна. De Telegraaf Голландын хамгийн олон 650 мянган уншигчтай өдөр тутмын сонин юм. Өдөр тутмын сонин зэрэгцээ үнэгүй тардаг 2 том сонин “Spits” /“De Telegraaf”-аас гаргадаг/, “Metro” /Metro International/ 450 мянган ширхэг сонинг олон нийтийн тээврийн хэрэгсэл, ресторан, кафе, их сургуулиуд, дэлгүүр зэрэг хүн олон цуглардаг газарт тараадаг байна. Мөн Недерландад 8 мянган нэр төрлийн сэтгүүл хэвлэгддэг.

Голландын ТВ, радиогийн нэвтрүүлэг нь нэг талаар арилжааны сувгууд, нөгөө талаас олон нийтийн сувгууд бүхий, засгийн газрын эзэмшдэг ТВ, радиогүй, хувийн байгууллагуудаар дамжуулж олон нийтийн ТВ, радио нэвтрүүлдэг өвөрмөц медиа бүтэцтэй юм. Мэдээллийн агентлаг ANP (Algemeen Nederlands Persbureau/ 2000 оноос тусдаа бие дааж компани болсон.

Интернэт хэрэглэгчдийн тоо маш өндөр, яг одоо ч гэсэн 10 сая Голланд хүн интернэт үзэж суугаа.<sup>45</sup> Хэвлэлийн нягтшил ихэсч, цөөхөн компани нэвтрүүлэг, сонин аль алийг эрхлэн гаргадаг болсноор шинэ хууль дүрэм хэрэгтэй гэж үзэх болсон. Мөн залуус ТВ үзэх нь багасч байна. Мөн сонин уншихаа больж байна. Тиймээс шинэ төрлийн дижитал медиа бүрийг хэвлэлийн эзэд үлэмж анхаарч судалж байна.

### Хэвлэлийн Консулын үүрэг

Дэлхийн II дайны дараа 1948 онд Недерландын Сэтгүүлчдийн Холбооны дэргэд Недерландын Хэвлэлийн Консулын эхлэл болох Сахилга батын консул Raad van Tucht байгуулагдаж, 1960 он хүртэл Хэвлэлийн Консулын үүргийг гүйцэтгэж байлаа. Энэ үед Консулын гишүүдэд зөвхөн сэтгүүлчид томилогддог байсан бөгөөд анхааруулга, сануулж донгодох, Сэтгүүлчдийн Холбооноос түр огцруулах, эсвэл хөөх хүртэл арга хэмжээ авдаг байлаа. 12 жил ажиллахдаа Консул 15 хэрэг шийджээ. Хэрэв тухайн сэтгүүлч Недерландын Сэтгүүлчдийн Холбооны гишүүн биш бол ямар ч арга хэмжээ авах боломжгүй байжээ.

---

<sup>45</sup> 6 наснаас дээш хүн амын 70 хувь гэсэн үг. Голланд айллуудын 60 хувь нь гэртээ өндөр хурдны интернэттэй. Интернэт хэрэглээгээр Европт толгой цохидог.

1960 онд Недерландын Хэвлэлийн Консул болох Raad voor de Journalistiek байгуулагдсан.

2010 онд Недерландын Хэвлэлийн Консул 50 жилийнхээ ойг тэмдэглэж, Европын Хэвлэлийн Консулуудын Холбооны жил тутмын уулзалтыг Амстердамд хийхээр төлөвлөж байна.

## Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

Хэвлэлийн Консулыг Сан хэлбэрээр байгуулж дараах байгууллагууд оролцдог:

- Недерландын Сэтгүүлчдийн Холбоо (Nederlands Vereniging van Journalisten, NVJ)<sup>46</sup>
- Недерландын Эрхлэгч нарын Нийгэмлэг (Nederlands Genootschap van Hoofdredacteuren)
- Недерландын үндэсний мэдээллийн агентлаг (Algemeen Nederlands Persbureau, ANP)

Хэвлэлээс:

- Голландын Сонины Эздийн Холбоо
- Голландын Сэтгүүл Хэвлэн нийтлэгчдийн Холбоо
- Голландын Орон нутгийн сонины Холбоо (Nederlandse Nieuwsblad Pers, NNP)

Олон нийтийн нэвтрүүлэг эрхлэгч телевизээс:

- The Nederlandse Omroep Stichting (NOS)
- Stichting Regionale Omroep Overleg en Samenwerking (ROOS)

Арилжааны телевизүүдээс:

- RTL Nederland, RTL-ийн Недерландын салбар
- SBS

Эдгээр дээр одоо интернэтийн Planet Internet байгууллага нэмэгдэж байна.

Дээрх сангийн Удирдах Зөвлөл Хэвлэлийн Консулын гишүүд, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилдог.

Хэвлэлийн Консул нь 4 дэд дарга, 13 сэтгүүлч, 13 сэтгүүлч бус гишүүдээс бүрдэнэ. Консулын дарга болон гишүүд энэ ажлаа жирийн ажлынхаа хажуугаар чөлөөт цагаараа хийдэг. Консулын дарга болон орлогч нь шүүгчид байна. Сэтгүүлч-гишүүд нь сонины эрхлэгч, редактор, эсвэл чөлөөт сэтгүүлч зэрэг сэтгүүл зүйн олон салбарт ажиллаж болно. Харин сэтгүүлч бус-гишүүд нь сэтгүүл зүйтэй ямар нэгэн байдлаар холбоотой нийгмийн ажил эрхэлдэг хүмүүс байна. Жишээ нь Сэтгүүл зүйн сургуульд хичээл заадаг профессор байж болно. Нарийн бичгийн дарга болон нарийн бичгийн даргын орлогч нь хуульч байна. Гишүүдийг дөрвөн жилийн хугацаатай томилдог ч арван жил хүртэл сунган томилж болно.

<sup>46</sup> Nederlandse Vereniging van Journalisten, NVJ нь 9 мянган сэтгүүлдчийг эгнээндээ нэгтгэсэн үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн байгууллага хоёрын нийлмэл бүтэц юм.

## Санхүүжилтийн эх үүсвэр

Хэвлэлийн Консулын Санг дээрх байгуулагч бүх байгууллагууд санхүүжүүлдэг: хэвлэл мэдээллийн байгууллагын эзэд 86.6 хувийг, Недерландын Сэтгүүлчдийн Холбоо, Недерландын Эрхлэгч нарын нийгэмлэг 6.7 хувийг санхүүжүүлдэг. Жилийн төсөв нь 130 000 орчим евро байдаг.

Засгийн газар санхүүжилтэнд оролцдоггүй. Бүх зардал төлбөр хэвлэл мэдээллийн салбараас гардаг. Сангийн Ерөнхийлөгч нэгэнтээ хэлэхдээ:

*“Ингэснээр Засгийн газрын хувьд сайн найз байх төдий үүрэг л үлддэг” гэжээ.*<sup>47</sup>

Жилийн төсөв 75 000 евро.<sup>48</sup> Уулзалт бүрт Хэвлэлийн Консулын гишүүд, туслахын хамт 45 еврогийн цалин авдаг. Энэ нь уулзах болгондоо 227 евро авдаг Босни-Герцеговинийн шинэхэн Хэвлэлийн Консултай харьцуулахад тун бага цалин юм.<sup>49</sup>

## Дүрэм журам

Недерландын Хэвлэлийн Консул нь Европын бусад Хэвлэлийн Консулуудаас ялгаатай нь нийтээр дагаж мөрдөх сэтгүүлчийн ёс зүйн бичмэл дүрэмгүй.

Сангийн Удирдах Зөвлөл Хэвлэлийн Консулын дүрмийг тогтооно.

Хэвлэлийн Консулын Сангийн дүрмийн 3 дугаар заалт ёсоор Хэвлэлийн Консул нь сайн сэтгүүл зүйг зөрчсөн талаарх гомдлыг шалгана. Хүн бүрийн гомдлыг биш, зөвхөн сэтгүүл зүйн хэргийн талаарх мэдүүлсэн гомдлыг авч үзнэ. Гомдол гаргагч нь өөрсдийнх нь талаар ташаа худал, буруугаар мэдээлсэн гэж үзсэн хувь хүн болон албан байгууллага байж болно.

Хэвлэлийн Консул хэвлэлийн эсрэг ерөнхий гомдлыг хүлээж авахгүй. Гомдол зөвхөн сэтгүүл зүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой хэвлэл, тодорхой нийтлэл материал нэвтрүүлэгт хаягласан байх ёстой.

Хэвлэлийн Консул нь үзэл бодлын консул бөгөөд сэтгүүлчид ялын тогтоол шийдвэр албадан тогтоож чадахгүй. Үүний зэрэгцээ Хэвлэлийн Консул гомдол гаргагчид санхүүгийн нөхөн төлбөр гаргуулж чадахгүй. Хэвлэлийн Консул нь гомдлын талаар өөрийн санал бодлыг гаргах бөгөөд шийдвэрээ вэбсайт болон сэтгүүлчдэд зориулсан мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлдэг. Мөн өөрийн шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлж зарладаг.

Гомдол гарагчийн санал хүсэлтэнд нийцүүлж, мөн сэтгүүлчийн ёс зүйн маргаанд дэмжлэг болох үүднээс ялангуяа үнэн зөв гомдлын талаарх Хэвлэлийн Консулын санал бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл нэвтрүүлэхийг чухал гэж үздэг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсөдтэй нь холбоотой Хэвлэлийн Консулын шийдвэрийг

---

<sup>47</sup> Annual report 2004, Stichting Raad voor de Journalistiek

<sup>48</sup> AIPCE, [www.presscouncils.org](http://www.presscouncils.org) 2005

<sup>49</sup> Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консулын жилийн төсөв 110 000 евро юм. Гэтэл Литвын Хэвлэлийн Консулын жилийн төсөв 28 000 евро хэдий ч жилдээ 200 орчим хэрэг шийдвэрлэдэг.

нийтэлж нэвтрүүлнэ гэсэн тохиролцоонд гарын үсэг зурсан байдаг. Харин зарчмын хувьд энэ гэрээг нь хэвлэлийн эрх чөлөөг гажуудуулж байна гэж үздэг зарим хэвлэлүүд энэ тохиролцоонд татгалзаж гарын үсэг зураагүй. Гэлээ ч бараг бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл Хэвлэлийн Консултай хамтран ажилладаг. Хэвлэлийн Консул гомдол зөв гэж үзсэн тохиолдолд шийдвэрийг нийтлэх хэвлэл 2/3 болж байгаа бөгөөд энэ тоо нэмэгдсээр байгаа юм.

## **Өргөдөл шийдвэрлэх механизм**

Гомдлыг гаргахад хялбархан. Гомдлоо бичээд Хэвлэлийн Консулд илгээхэд болно. Төлбөр авахгүй. Зайлшгүй биш ч хүсвэл өмгөөлөгч авч болно.

Гомдлыг хүлээн авсаны дараа нарийн бичгийн дарга энэхүү гомдлыг тухайн сэтгүүлч эсвэл эрхлэгчид илгээгээд 3 долоо хоногийн дотор хариу бичихийг хүснэ. Ихэнх тохиолдолд олон нийтийн шүүхийн хугацааг тохирдог.

Хэвлэлийн Консул гомдлыг шийдвэрлэх хамгийн сайн арга нь боломжтой бол хоёр талын санал бодлыг сонсох явдал гэж үздэг. Заримдаа аль нэг тал ирэхийг хүсэхгүй байх нь бий.

Хэлэлцүүлгийн үеэр хоёр тал өөр өөрийн байр суурь өнцгөө тайлбарлана. Дараа нь Хэвлэлийн Консул асуулт асууж, сэтгүүлчийн ёс зүйн зарчим хэм хэмжээний талаар, энд ямар хэм хэмжээ хамаарч байгааг тайлбарлана.

Нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс гомдол сэтгүүл зүйн үйл ажиллагаанд хамаагүй, эсвэл шууд холбоогүй гэж үзвэл Хэвлэлийн Консулд танилцуулаад зөвшөөрч болох эсэхийг асуудаг. Хэрэв Консулын эрх мэдлийн хэмжээнд бол Консул хэлэлцэх хуралгүйгээр хэргийг шийдвэрлэдэг.

Хэвлэлийн Консул нэг хурлын үеэр 4-5 гомдлыг хэлэлцдэг. Хурлын ирц гурваас доошгүй, таваас олонгүй гишүүд оролцож байж хүчин төгөлдөр болно. Сэтгүүлч мэргэжилтэй гишүүд, сэтгүүлч бус мэргэжилтэй гишүүдийн тоо тэнцэх ёстой. Өөрөөр хэлбэл дарга дээр нэмэгдээд 1/1, 2/2 байна гэсэн үг. Хэрэв хэн нэг нь гэнэт хуралдаанд оролцож чадахгүй бол талууд зөвшөөрвөл одоо байгаа 4 гишүүний ирцтэй хуралдаж болно. Хэргийг сонссоны дараа Хэвлэлийн Консул хаалттай хаалганы цаана хэргийг хэлэлцэнэ. Тэр үеэр нарийн бичгийн дарга шийдвэрийн төслийг боловсруулдаг. Хэвлэлийн Консулын Ерөнхийлөгч болон гишүүдийн тайлбарыг нэгтгээд заргалдагч хоёр талд танилцуулж илгээдэг. Энэ нь шүүх хуралдаанаас хойш 8 долоо хоногийн дотор гэсэн үг.

## **Шийдвэрийг олон нийтэд танилцуулах**

Хоёр талд шийдвэрээ танилцуулсны дараа Хэвлэлийн Консул өөрийн вэбсайт болон сэтгүүлчдэд зориулсан мэргэжлийн сэтгүүлд нийтэлдэг.

## Хууль зүй болон бусад асуудлууд

Недерландын Хэвлэлийн Консул нь Европын бусад Хэвлэлийн Консулуудаас ялгаатай нь нийтээр дагаж мөрдөх сэтгүүлчийн ёс зүйн бичмэл дүрэмгүй.

Хэвлэмэл бичгийн дүрэм нь олон нийт болон сэтгүүлчдийн хувьд ямар стандартыг сэтгүүлч дагаж мөрдөх ёстойг тод зааж ойлгомжтой болгоно гэж нэг хэсэг нь үздэг. Нөгөө талаар сэтгүүл зүй хатуу дүрэмд захирагдахад бэрхшээлтэй. Олон заалт бүхий урт дүрмийг дагаж мөрдөхөд төвөгтэй. Амьдрал баян. Дүрэмд тусгагдаагүй хэргийг яаж шийдэх вэ? Үүний зэрэгцээ ёс зүйн дүрэм нь цөөн тооны нээлттэй хэм хэмжээтэй ерөнхий дүрэм байвал зохистой гэж нөгөө хэсэг нь үздэг. Хэдий тийм боловч Хэвлэлийн Консулын гаргасан түрүүчийн шийдвэрүүдээс ёс зүйн хэм хэмжээ тогтож болно гэж үзжээ.<sup>50</sup>

Хэвлэлийн Консулын гаргасан шийдвэр нь сайн сэтгүүл зүйн үйл ажиллагааны хэм хэмжээг тодорхойлж, улмаар эдгээр хэм хэмжээг хөгжүүлэхэд чиглүүлж хандуулах болно гэж Голландын сэтгүүл зүй үздэг. Байнга өөрчлөгдөн хувьсаж байгаа нийгэмтэй хамт сэтгүүл зүйн дагаж мөрдөх хэм хэмжээ ч өөрчлөгддөг. Хэвлэлийн Консул энэ санааг аль болохоор тээж байдаг. Энэ нь Хэвлэлийн Консулын томъёолсон хэм хэмжээ нь хөдөлшгүй нугаршгүй гэсэн үг биш, нийгмийн шаардлагаар зохицуулагдаж байдаг.

Дээрх нь Недерланд огт дүрэмгүй гэсэн үг биш юм. Зарим хэвлэл мэдээлийн хэрэгсэл дотооддоо өөрийн ёс зүйн дүрэмтэй. Хоёр ерөнхий дүрэм түгээмэл үйлчилдэг: нэг нь Олон улсын Сэтгүүлчдийн Холбооны Сэтгүүлчдийн ёс зүйн тунхаг<sup>51</sup>, нөгөө нь Недерландын Эрхлэгч нарын нийгэмлэгийн зарласан ёс зүйн дүрэм юм. Гэлээ ч эдгээр дүрэмнүүд Хэвлэлийн Консулын шийдвэрт нөлөөлдөггүй. Гэвч Хэвлэлийн Консулын шийдвэрт эдгээр ёс зүйн дүрмийн нийтлэг хэм хэмжээ агуулагдаж байдаг.

Сүүлийн жилүүдэд Недерландын Хэвлэл Консулын хаягаар ирдэг гол шүүмжлэл бол албадах эрх мэдэл нөлөөгүй байгаа байдал юм.

1993 оноос Консул гомдол гаргагч болон сэтгүүлчийн хооронд зуучлах болсон. Тэр жил гарсан өөр нэг томоохон өөрчлөлт нь Хэвлэлийн Консул өөрийн санаачилгаар сэтгүүл зүйн үндсэн зарчмыг хамгаалах болсон явдал юм. Үүнээс хойш гурван удаа Хэвлэлийн Консул сэтгүүл зүйн ёс зүйн хэм хэмжээг хамгаалаад байна. Сэтгүүлчийн хулгайлсан мэдээллийг нийтэлсэн (RvdJ 1995/32), нууц камер болон микрофон ашигласан (RvdJ 1996/44), мэдээлэлд хориг тавьсан (RvdJ 2003/50) явдлын талаар Консул шийдвэр гаргажээ.

2003 оны 1 дүгээр сараас гомдол гаргагч нь гомдлоо богино хугацаанд шийдүүлэхээр хүсэлт гаргах боломжтой болжээ.

Хэвлэлийн Консул хэрэг шийдэхдээ үүнээс өмнө адил төстэй хэргүүдийг хэрхэн шийдсэнээс жишээ авч шийдвэр гаргадаг. Одоо Хэвлэлийн Консул 4 долоо хоногийн дотор шийдвэр гаргаж байна.

<sup>50</sup> Daphne C. Koene, secretary, The Netherlands Press Council. An Introduction. 7th annual AIPCE meeting. 29 September 2005, Luxembourg

<sup>51</sup> Code of Bordeaux



Сүүлийн жилүүдэд Хэвлэлийн Консулын ачаалал нэмэгдэх болсон нь сэтгүүлчид ёс зүйгээ зөрчих нь нэмэгдсэнээс биш, харин хэвлэлд гомдогсод Хэвлэлийн Консулд хандахыг илүүд үзэх болсноос ажээ. 2004 онд Хэвлэлийн Консул 89 гомдол хүлээн авч, 100 орчим шийдвэр гаргажээ. Эдгээр шийдвэрээс 29 нь дэмжигдэж, 19 нь хагас дэмжигдэж, 45 нь буцаагджээ. 10 удаагийн гомдол зөвшөөрөхүйц гомдол байжээ.

Консул талуудын танилцуулсан баримтыг мөрдөн шалгадаггүй.

Гомдлын ихэнх нь хувийн нууцтай холбоотой иржээ. Үлдсэн хувь нь сэтгүүлч түүний талын хэлсэн үгийг сонссонгүй, буруу мэдээлсэн гэж үзэж гомдол мэдүүлжээ.

Голландын хэвлэлийн бодлогын үндэс нь Үндсэн хуулийн 7 дугаар зүйл юм. Зар сурталчилгааг хэвлэлийн эрх чөлөөнөөс хасч тооцдог. Тамхи, архи, эм тариаг сурталчлахыг хориглосон, эсвэл хязгаарласан хуультай.

Хэвлэл мэдээллийн хууль нь радио, телевизийг зохицуулдаг ч нэвтрүүлгийн агуулга программд цагдан хяналт байхгүй. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бодлого нь ерөнхийдөө нэвтрүүлгийн бодлого, түүн дотроо олон нийтийн нэвтрүүлгийн тогтолцоо байгууллагыг хамгаалах агуулгатай байдаг. Европын Холбооны "Хил хязгааргүй телевиз" директив нь Голландын энэхүү хуулинд үндэслэж зохиогдсон юм.

## 2.4 ШВЕДИЙН ХЭВЛЭЛИЙН КОНСУЛ

### Суурь мэдээлэл

Одоогоос 240 жилийн өмнө үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхээ хуульчлан тогтоосон орны хувьд бусдад харуулах туршлага байх нь гарцаагүй. 1930 оноос 2006 он хүртэл социал демократууд засгийн эрх барьж байсан явдал хүчирхэг нийгмийн халамжийн системтэй болоход нөлөөлжээ.

Скандинавын орнуудаас хамгийн том болох 9 сая хүнтэй Шведийн насанд хүрсэн хүн амын 80 хувь нь өдөр бүр сонин уншдаг. 160 сонин гарч байгаагаас өдөр тутмын сонин 36 сая хувь хэвлэгдэж, 1000 хүнд 420 сонин оногдож байна.<sup>52</sup> 2005 оны байдлаар үнэгүй тардаг өдөр тутмын сонины хэвлэлийн хэмжээ 0.9 саяд хүрч байсан юм. Сонины зах зээлийн 1/4-ийг Bonnier Group эзэмшдэг. Хоёр дахь том бүлэг нь Guteborgs-Posten өдөр тутмын сонины зэрэгцээ орон нутгийн сонин маш олныг эрхлэн гаргадаг Stampen Group юм. Сонины зах зээл рекламн орлогоо ТВ-д алдахын хэрээр төлбөртэй сонины эрэлт аажимдаа унаж, харин үнэгүй тараадаг сонин олширч байна.

Европтой харьцуулахад ТВ үзэхэд бага цаг зарцуулдаг ч Шведийн хүн амын 74 хувь радио сонсдог, 86 хувь телевиз үздэг.<sup>53</sup>

Шведийн олон нийтийн ТВ болох Sveriges Television /STV/ нь STV1, STV2, STV24 сувгуудтай бөгөөд нийт үзэгчдийн 38.5 хувь нь үздэг байна. Харин хамгийн том арилжааны суваг болох TV4-ийг 23.2 хувь үздэг бол үлдсэн хувийг хиймэл дагуулын 5 суваг /TV3, Kanal 5, ZTV, TV6, TV8/ хуваадаг байна.

Шведийн хэвлэл мэдээллийн ертөнц нь цөөн тооны хүчирхэг байгууллагуудаараа бусад улсаас онцлог. Сонины хэвлэлийн эздийн холбоонд (Tidningsutgivarna –TU) Шведийн бараг бүх сонин нэгддэг. Радио ТВ-ийн салбарт түүнтэй дүйцэх холбоо байхгүй. Үүний зэрэгцээ Шведийн Сэтгүүл хэвлэн нийтлэгчдийн холбоо (Sveriges Tidskrifter), 18 мянган гишүүнтэй Шведийн Сэтгүүлчдийн Эвлэл (Svenska Journalistförbundet – SJF)<sup>54</sup>, Шведийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ёс зүг хариуцдаг Хэвлэн нийтлэгчдийн Клуб (Publicistklubben - PK) зэрэг байгууллагууд идэвхтэй ажилладаг.

Хэвлэлийн эрх зүйн зохицуулалт нь хэвлэлийн эрх чөлөөний өнө удаан уламжлалд үндэслэж, 1766 оны суурь хуулиар зохицуулагддаг. Интернет сонин мөн адил энэ хуулиар зохицуулагддаг. Харин ТВ радиогийн агуулгад эрх чөлөө нь Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний параллель суурь хуулиар хамгаалагддаг. Радио ТВ-ийн хуулиар бусад нарийвчилсан асуудлууд зохицуулагддаг. Бусад хуулиуд байгууллагын зохион байгуулалт болон техникийн асуудлыг зохицуулдаг байна.

1970 оны эхэн үеэс эхлэн Засгийн газар сонинуудад төрөөс татаас санхүүжилт өгдөг болсон бөгөөд хөнгөлөлттэй НӨАТ-ын (бусадтай адил 25 хувь биш 6 хувь) бодлогоор

<sup>52</sup> 2005 онд. www.ejc.net

<sup>53</sup> 2005 оны байдлаар

<sup>54</sup> Сэтгүүлчид бараг 100 хувь элссэн, цэвэр мэргэжлийн байгууллага

дэмждэг байна. Цаашдын хэвлэл мэдээллийн салбарын чиг хандлагын тухайд зарим хэвлэл мэдээллийн компаниуд интернэтэд өөрийн хяналтаа тогтоож эхлээд байгаа бөгөөд зөвхөн сүлжээнд ажилладаг мэдээллийн хэрэгсэл байхгүй байгаа юм. Шведийн томхон медиа компаниуд орлогынхоо тэн хагасыг гадаадаас, гол нь ном, сэтгүүл, сонингоос олж байна.

## Хэвлэлийн Консулын үүрэг

Одоо хэвлэлийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Хэвлэлийн Омбудсмэн хүлээн авч, өргөдөл гаргагчтай тохиролцдог.

Тухайн хэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой бол сайн сэтгүүл зүйн үзэл баримтлалыг практикт хэрхэн хэрэглэснийхээ төлөө Шведийн Хэвлэлийн Зөвлөл<sup>55</sup> хариуцлага хүлээнэ. Уг асуудал нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй холбоогүй бол Омбудсмэн рүү шилждэг. Хэвлэлийн Зөвлөл болон Хэвлэлийн Омбудсмэн нь зөвхөн сонин хэвлэлийн асуудлыг хариуцна. Харин телевиз болон радиотой холбоотой хэргийг Өргөн нэвтрүүлгийн комисс авч үздэг.

## Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

Шведийн хэвлэлийн хариуцлагын систем урт түүхтэй. Сонины сэтгүүлчид, хэвлэн нийтлэгч, зохиолчдыг багтаасан Хэвлэн нийтлэгчдийн Клуб (PK) 1900 онд хэвлэл нийтлэлд үнэн шударгыг тунхаглан байгуулагджээ. Хэвлэлийн байгууллагууд Хэвлэлийн Омбудсмэныг байгуулсанаар 1950-60 онуудад дүрэм нь шинэчлэгджээ. 1968 онд Шведийн Сэтгүүлчдийн Холбоо (SFJ) мэргэжлийн ёс зүйн дүрмийг баталжээ.

Шведийн хариуцлагын систем нь үндсэн гурван дүрэмд тулгуурладаг:

- Хэвлэн нийтлэлийн дүрэм (сайн сэтгүүл зүйн дүрэм): үнэн зөв мэдээлэх, хувийн нууцыг хүндлэх, залруулга гаргах эрх, гэрэл зураг зэрэг асуудлыг зохицуулдаг.
- Мэргэжлийн сэтгүүл зүйн дүрэм: Энэхүү дүрэм нь мэргэжлийн сэтгүүл зүйн ёс зүй болон сэтгүүлчдийн шударга, цэвэр байдал, мэдээллийг олж авах, мэдээллийн эх сурвалжийн харилцаа зэргийг зохицуулдаг.
- Редакцийн сурталчилгааны дүрэм: Энэхүү хуучин дүрмүүд нь редакцийн байр суурь болон сурталчилгааны зааг ялгааг тогтоодог байсан юм. Мэдээ нь мэдээллийн үнэ цэнийг шүтэхээс биш сурталчилгааны үнэлэмжгүй байх зэрэг.

Хэрэглэгч болох үзэгч уншигчийн зүгээс хариуцлагын систем байхгүй, зөвхөн цөөн тооны ажиглах бүлэг цагаачлал гэх зэрэг асуудлаар хэвлэлийг ажиглаж мониторинг хийдэг байна.

Шведийн Хэвлэлийн Консул 1916 онд байгуулагдсан бөгөөд дэлхийн ийм төрлийн байгууллагын хамгийн эртнийх нь юм. Хэвлэлийн Консул нь тус байгууллагыг даргалдаг шүүгч, Хэвлэлийн Консулыг бүрдүүлдэг Шведийн Сонин хэвлэн нийтлэгчдийн холбоо, Шведийн Сэтгүүлчдийн Эвлэл, Үндэсний Пресс клуб зэрэг дөрвөн байгууллага тус бүрээс нэг төлөөлөгч, сонин хэвлэлийн бизнестэй холбоогүй, олон нийтийн гурван төлөөлөгчөөс бүрддэг байлаа.

<sup>55</sup> Pressens Opinionsndmnd, PON: [www.po.se](http://www.po.se)

Хэвлэлийн Омбудсмэний алба 1969 онд байгуулагдсан.<sup>56</sup> Үндэсний хэвлэлийн клубын дарга, Шведийн хуульчдын Холбооны дарга, Парламентын Омбудсмэны дарга нараас бүрдсэн тусгай хороо Хэвлэлийн Омбудсмэнийг томилдог. Хэвлэлийн Омбудсмэний алба байгуулахаас өмнө сайн сэтгүүл зүйтэй холбоотой гомдлыг Хэвлэлийн Консул шийдэж байсан юм. Одоо эхлээд хэвлэлтэй холбоотой гомдлыг Хэвлэлийн Омбудсмэн хүлээн авдаг. Мөн тэрээр өөрийн санаачилгаар хэрэг эхэлж шалгах эрхтэй. Хэрэв хэрэг үүсгэх хангалттай баримттай гэж үзвэл Хэвлэлийн Консулд шилжүүлдэг.

### **Санхүүжилтийн эх үүсвэр**

Хэвлэлийн Консул нь Шведийн Сонин хэвлэн нийтлэгчдийн холбоо, Шведийн Сэтгүүлчдийн Эвлэл, Үндэсний Пресс клуб зэрэг хэвлэлийн дөрвөн байгууллагаас бүрэн санхүүждэг. Эдгээр дөрвөн байгууллага Шведийн хэвлэл мэдээллийн байгууллага, нэвтрүүлгийн ёс зүйн кодыг боловсруулдаг.

Хэвлэлийн Омбудсмэнд гомдол гаргахад үнэ төлбөргүй.

### **Дүрэм журам**

Ёс зүйн дүрмийг Шведийн Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааны зөвлөл 1978 онд баталж, 1995 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тус Зөвлөлд Хэвлэн нийтлэгчдийн клуб, Шведийн Сэтгүүлчдийн Холбоо, Шведийн Хэвлэн нийтлэгчдийн Холбоо, Шведийн радио, Шведийн Телевиз, Боловсролын радио, Радио Өргөн нэвтрүүлгийн Холбоо зэрэг байгууллага багтдаг.

## **ШВЕДИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ, СОНИН ХЭВЛЭЛИЙН СЭТГҮҮЛЧДИЙН МӨРДӨХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

### **Мэдээллийн үнэн зөв байдлыг хангана**

1. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нийгэмд гүйцэтгэх үүрэг нь олон нийтийн итгэх итгэлийг бий болгохын тулд үнэн зөв, олон талын мэдээлэл дамжуулахыг шаардаж байдаг.
2. Мэдээллийн эх сурвалжид шүүмжлэлтэй хандах хэрэгтэй. Нөхцөл байдал ямар байна, тэр хэмжээгээр мэдээллийг нарийн нягт шалгах, тэрчлэн урьд өмнө нь нийтэлсэн мэдээллийг ч гэсэн нягталж шалгах хэрэгтэй. Уншигч сонсогч үзэгчдэд баримтыг тайлбараас ялгаж салгаж олгох боломж олгоно.
3. Зарлал, гарчиг, зар мэдээ нь холбогдох тексттэй байх ёстой
4. Гэрэл зураг жинхэнэ эсэхийг шалгах. Тайлбар зураг, график нь үнэн зөв байхаас гадна эдгээр нь хүмүүсийг төөрөгдөлд оруулж болзошгүй далд санаатай байх ёсгүй.

---

<sup>56</sup> Allmänhetens Pressombudsman, PO

### **Алдаагаа засахад бэлэн байх**

5. Алдаа гаргасан нь нотлогдсон бол эхний шаардлагаар засч залруулна. Хэрэв тухайн хүн хангалттай үндэслэлээр тухайн мэдээллийг няцаах хүсэлтэй байвал түүнд үүнийг биелүүлэх боломж олгох хэрэгтэй. Мэдээллийг няцаасан, эсвэл залруулга хийснийг тухайн материалыг уншсан хүмүүс шууд анзаарахаар нийтэлнэ. Мэдээллийг няцаах тохиолдол бүрт редакцын тайлбар шаардлагагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.
6. Шведийн Хэвлэлийн Зөвлөлөөс тухайн сонин хэвлэлийг буруутгасан шийдвэр гаргасан бол түүнийг нэн даруй нийтлэх

### **Хүний хувийн халдашгүй байдлыг хүндэлнэ**

7. Анхааралтай байх. Тухайн хүний хувийн амьдралтай холбоотой баримтыг нийтэлснээр түүний хувийн амьдралд зовлон учирч болзошгүй. Зөвхөн олон нийтийн эрх ашгийн төлөө ийм алхам хийнэ.
8. Амиа хорлохыг завдсан, амиа егүүтгэсэн тухай мэдээ материал нийтлэхдээ тун болгоомжтой хандах. Ийм мэдээ нийтлэл нь ойр дотны хүмүүсийн сэтгэлийг нь шархлуулж, түүний хувийн амьдралын эрхийг зөрчиж болзошгүй юм.
9. Золгүй явдал, гэмт хэргийн хохирогчийн талаар мэдээ материал бэлтгэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Мэдээ, нийтлэлд хохирогчийн нэрийг дурдсанаар хохирогч, түүний ойр дотны хүмүүст сэтгэл санааны ноцтой хохирол учирч болзошгүй юм.
10. Тухайн хүний яс үндэс, арьс өнгө, мэргэжил, улс төр, шашин шүтлэг, бэлгийн зуршил зэрэгт онцгой анхаарал хандуулах хэрэггүй. Ийм зүйлийг зөвхөн мэдээ нийтлэлийн далд санаа, агуулгын хувьд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл авч үзэж болно.

### **Гэрэл зургийг нийтлэхдээ анхааралтай хандах**

11. Дээр дурдсан дүрэм гэрэл зургийн сурвалжлаганд ч мөн хамаарна.
12. Гэрэл зургийн эвлүүлэг, техникийн шинжтэй бусад өөрчлөлт нь уншигчдыг төөрөлдүүлж, буруутөсөөлөлтэй болгож болохгүй. Гэрэл зурагт холбогдох тайлбарыг зайлшгүй хавсаргах ёстой. Энэ нь архивын материалд ч мөн хамаатай.

### **Хоёр талын байр суурийг сонсоно**

13. Шүүмжлүүлсэн хүнд хариулт өгөх боломж олгоно. Зарим тохиолдолд шүүмжлэл нь шүүмжлэлд өртөж байгаа хүнийг сэтгэл санаагаар унагахад чиглэгдсэн байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй.
14. Эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүн гэм буруутай нь шүүхээр нотлогдоогүй үед түүнийг хуулиар буруугүй гэж үздэгийг санах хэрэгтэй. Сонинд бичигдсэн материалын талаар дээд шатны шүүхээс гаргасан шидвэрийн өөрчлөлтийг мэдээлэх ёстой.

## Нэр дурдахдаа болгоомжтой байх

15. Тодорхой нөхцөлд тухайн хүний нэрийг нийтэлснээр тэр хүний амьдралд ямар үр дагавар учрахыг бодолц. Зөвхөн олон нийтийн эрх ашиг хөндөгдөх тохиолдолд нэрийг нь илчилнэ.
16. Тухайн хүний нэрийг дурдахгүй гэж үзэж байгаа бол тухайн хүнийг хэн болохыг хэлж өгөх ямар ажил эрхэлдэг, албан тушаал, нас хүйс, үндэс угсаа зэрэг мэдээлэл мөн гэрэл зургийг нийтлэхээс зайлсхий.
17. Тухайн хүний нэр, гэрэл зургийг нийтэлсэн хариуцлагыг энэ мэдээллийг түгээсэн хүн хүлээнэ гэдгийг ойлгох хэрэгтэй.

## Өргөдөл шийдвэрлэх механизм

Хэвлэлийн Омбудсмэн өөрийн санаачилгаар аливаа хэргийг авч үзэх эрхтэй.

Сонинд нийтэлсэн материал сайн сэтгүүл зүйг зөрчсөн гэж үзсэн нийгмийн гишүүн хэн боловч Хэвлэлийн Омбудсмэнд гомдол гаргах эрхтэй. Хэвлэлд нийтлэгдсэн нийтлэлд дурдагдсан хүн өргөдлөө бичгээр өгнө.

Өргөдлийг хүлээж авсаны дараа Хэвлэлийн Омбудсмэн хэвлэлээр залруулга хийх, эсвэл шүүмжлэлд өртсөн хүний тайлбарыг сонинд тавих эсэхийг шийднэ.

Хэвлэлийн Омбудсмэн энэ зорилгоор сонинтой холбоо барьж болно. Маргааныг энэ аргаар зохицуулж чадаагүй бол Хэвлэлийн Омбудсмэн хэргийг шалгаж байцаалт авч болно. Үүний дараа Хэвлэлийн Омбудсмэн хэвлэлийн эрхлэгчээс гомдол гаргагчийн буруутгаж байгаа асуултанд хариу өгөхийг шаардана. Мөн гомдол гаргасан хүнд сонины хариултанд хариу тайлбар хийх боломж олгоно. Гомдол гаргагч дүрмийн дагуу нийтлэл хэвлэгдсэнээс хойш гурван сарын дотор өргөдөл өгнө.

Байцаалт авч, хэргийг шалгаж дуусаны дараа Хэвлэлийн Омбудсмэнд шийдвэр гаргах хоёр хувилбар байдаг:

- Тухайн хэргээс үүдэн гарсан сонинг албан ёсоор буруутгах шаардлагагүй гэж үзэх. Хэрэв Хэвлэлийн Омбудсмэн хэрэгсэхгүй гэж үзвэл гомдол гаргагч шууд Хэвлэлийн Консулд давж заалдаж болно. Хэвлэлийн Консул болон Хэвлэлийн Омбудсмэн өргөдлийг авч үзсэний дараа гомдол гаргагч шүүх байгууллагад хандах эрх нээлттэй үлдэнэ.
- Цуглуулсан баримт нь Хэвлэлийн Консул шийдвэр гаргах хэмжээнд бол шилжүүлэх

## Шийдвэрийг олон нийтэд мэдээлэх

Сэтгүүл зүйн ёс зүйг зөрчсөн хэвлэл Хэвлэлийн Консулын бичгээр гаргасан шийдвэрийг заасан хэмжээнд нийтэлнэ.

Мөн тус хэвлэл захиргааны арга хэмжээний торгууль төлнө.

Жилдээ 350-400 орчим гомдол Хэвлэлийн Омбудсмэн бүртгэж авсан бөгөөд гомдлын олонх нь хувин нууцад халдсан тухай болон гэмт хэргийн сурвалжлагын талаар гарчээ. Хэвлэлийн Омбудсмэны хүсэлтээр болон түүний хэрэгсэхгүй гэж үзсэн хэргээр гомдол гаргагч давж заалдсанаар нийт гомдлын 30 хувийг Хэвлэлийн Консул авч үзжээ.

Гаргасан гомдол үндэслэлгүй, мөн гомдол гаргагчийн тайлбар заруулгыг сонинд нийтэлсэн зэрэг олон шалтгааны улмаас нийт гомдлын 70 орчим хувийг хэрэгсэхгүй болгожээ.

Нийт гомдлын 10-15 хувьд Хэвлэлийн Консулын шийдвэрээр тухайн хэвлэлийг албан ёсоор буруутгасан байна.

Зөвлөлийн шийдвэрийг тухайн асуудалд холбогдсон сонин хэвлэл болон “Хэвлэлийн сэтгүүл”, “Сэтгүүлч” сэтгүүлд нийтэлдэг байна. Зөвлөлийн шийдвэрийн тухай тайлбарыг Шведийн Хэвлэн нийтлэгчдийн Холбооны төв хэвлэлд бас нийтэлдэг.

### **Хууль зүй болон бусад асуудлууд**

Шведийн өөрийн зохицуулалтын байгууллага нь хууль эрх зүйд тулгуурладаггүй. Сайн дурын үндсэн дээр үл ажиллагаагаа явуулдаг.

## 2.5 БОСНИ-ГЕРЦИГОВИНИЙН ХЭВЛЭЛИЙН КОНСУЛ

### Суурь мэдээлэл

Урт удаан үргэлжилсэн дайны дараах энх тайван, сүйрсэн эдийн засаг, улстөрийн төвөгтэй тогтолцоо зэрэг нь Босни-Герцеговинийн хэвлэл мэдээлэлд ихээхэн нөлөөлсөн юм. 1995 оны 12 дугаар сард Дэйтоны энхийн хэлэлцээрт гарын үсэг зурснаар дөрвөн жил үргэлжилсэн дайн зогсож, хорват, серби, босни гурван угсаатан бүхий холбооны улс бүрэлджээ. Өнөөдрийн Босни нь сербүүд ноёлсон Сербийн БНУ (Republic of Srpska), хорват босничуудаас бүрэлдсэн Босни-Герцеговинийн Холбооны улсаас бүрдэж байна. Босни-Герцеговинийн хэвлэл мэдээллийг Европын консул, Irex ProMedia, Нээлттэй Нийгэм хүрээлэн зэрэг олон улсын байгууллагууд чухал ач холбогдол өгч анхаарч чиглүүлж маш их хөрөнгө оруулалт хийж ирлээ. Үүний зэрэгцээ Дэйтоны хэлэлцээрээр Босни-Герцеговинийн Дээд Төлөөлөгчдийн Засгийн газарт (OHR) хууль батлах, улстөр, эдийн засгийг удирдах бүрэн эрх өгсөний дотор хэвлэл мэдээллийн салбар ч мөн хамаарч байгаа юм. Нэг талд үндсэрхэг үзэлтнүүд, нөгөө талд ардчилсан хүчин, олон улсын байгууллагууд, Засгийн газар талцсан тэмцэл өнөөгийн энэ улс орны төрхийг тодорхойлж байна.

Боснид 600 орчим хэвлэл байна. Хэвлэлийн чанар болон эдийн засгийн боломжоос шалтгаалан сонин унших хүмүүс Боснид угаасаа цөөн байсны дээр одоо улам ч цөөрчээ. Үүний дээр уншигчдын үндэс угсаанаас шалтгаалж сонинуудын агуулгыг ихээхэн хязгаарладаг.

Зургаан өдөр тутмын сонин хэвлэгдэж байгаагийн дөрөв нь Босни-Герцеговинд нийтлэгдэж байна. "Dnevni Avaz", "Oslobodjenje", "Jutarnje Novine" сонинууд Сараевод, "Dnevni List" сонин Мостарт тардаг. "Nezavisne Novine", "Glas Srpski" сонинууд Сербийн БНУ-ын Банжа Лукад хэвлэгдэж байна. Сонины зах зээл тогтворгүйгээс уг сонингууд хэдэн хувь хэвлэгдэж байгаа талаар тодорхой тоо баримт байдаггүй.

Сонины зэрэгцээ 183 нэвтрүүлгийн станц лиценз авсанаас үндэсний хэмжээнд цацагддаг олон нийтийн ТВ болох гурван суваг Босни-Герцеговинийн Олон нийтийн нэвтрүүлэг (Public Broadcasting Service of BiH - PBS BiH), Босни-Герцеговинийн Холбооны Улсын Радио ТВ (RTV FBiH) болон Сербийн БНУ-ын Радио ТВ (RTRS) ажиллаж байна. Үүний зэрэгцээ 42 ТВ, 141 радио ажилладаг. Нийтдээ тус улсад 78 олон нийтийн, 105 хувийн радио ТВ нэвтрүүлгээ цацаж байна. Үүний 16 нь олон нийтийн ТВ, 26 нь хувийн ТВ юм. Харин кабель ТВ байхгүй. Интернет Европт хамгийн бага хөгжсөн орон юм.

1990 оны сүүлийн хагаст хэвлэл мэдээллийг үндэсэрхэг үзэлт улстөрийн намуудаас салгаж, шинээр хууль эрх зүйн орчин бүрдүүлэхэд гадны олон улсын байгууллагууд болох OSCE, USAID and OSI ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Нэвтрүүлгийн мэдээллийн хэрэгслүүдийг зохицуулах Холбооны Зохицуулалтын хууль, Мэдээлэл олж авах эрхийн тухай хууль, Гүтгэлэг, гүжирдлэгийн тухай хууль зэрэг хуулиуд 2001 онд батлагдсан.

2002 онд Олон нийтийн нэвтрүүлгийн Системийн тухай болон Босни-Герцеговинийн Олон нийтийн радио, ТВ-ийн тухай хууль батлагдсан.



Хэвлэл мэдээллийн хариуцлагын зонхицуулалтыг Холбооны Зохицуулах Агентлаг (Communications Regulatory Agency -CRA) Босни-Герцеговинд Омбудсманаар дамжуулан зохицуулдаг. Харин Сербийн БНУ-д CRA-ын төлөөлөл байхгүй.

## Хэвлэлийн Консулын үүрэг

1999 онд сэтгүүлчдийн байгууллагууд Хэвлэлийн ёс зүйн дүрэм баталсан. Энэхүү Хэвлэлийн ёс зүйн дүрэм нь сэтгүүлчдийн ёс зүйн стандартыг өргөх, үнэн зөв мэдээлэх эрхийг хамгаалах, иргэдийг хүндэтгэхэд онцлон анхаарсан. Энэхүү Хэвлэлийн дүрэмд сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг, өс хонзонд өдөөн турхирах, ялгаварлан үзэх үзэл, үзэн ядахгүй байхыг, баримтат үнэнийг хүндлэхийг зөвлөсөн байдаг. Мөн хүүхэд болон хувийн нууцыг хамгаалах суурийг энэ дүрмээр тавьсан юм.

2000 оны 9 дүгээр сард Хэвлэлийн Консул байгуулсан. Хэвлэлийн Консул нь Хэвлэлийн ёс зүйн дүрэмд үндэслэж, хэвлэлийн мэдээллийн эсрэг иргэдийн гомдлыг авч үзэж, маргаан хэрүүлийг боломжтой сэтгүүл зүйн аргаар шийдвэрлэдэг.

“Үнэний төлөө иргэд сэтгүүлчид хамтран тэмцье” гэсэн уриатай энэ байгууллага:

- **Зуучлах:** Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэргэжлийн бус мэдээлэл санаанд нь таараагүй иргэн ба сонины хооронд зуучлах
- **Хянах:** Босни-Герцеговинийн Хэвлэлийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэх
- **Стандарт:** Сонин хэвлэлийн мэргэжлийн хэм хэмжээг дээшлүүлэх
- **Олон нийтийг хамгаалах:** Олон нийтийг мэргэжлийн бус, захиалгат сэтгүүл зүйн мэдээллээс хамгаалах
- **Хэвлэлийг хамгаалах:** Хэвлэлийн эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөг зөрчиж түгшээсэн улстөр, эдийн засгийн болон бусад хэлбэрийн дарамтаас хамгаална гэж тунхагладаг.<sup>57</sup>

## Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

Консул хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийг төлөөлсөн 6 сэтгүүлч, 6 олон нийтийн төлөөлөгч, олон улсын байгууллагаас томилогдсон даргатай байна. 2000 онд Холбооны улсын түвшинд ажиллахаар байгуулагдсан. Энэ нь Зүүн Өмнөд Европт хэвлэлийн өөрийгөө зохицуулах зарчмыг амжилттай үндэслэсэн хамгийн анхны байгууллага байлаа. Анхны үүсгэн байгуулагч нь Босни-Герцеговинийн Сэтгүүлчдийн Холбоо байв. Анхны гүйцэтгэх захирал нь Их Британийн Хэвлэлийн Консулын дарга лорд Жон Вэкихэм байсан.

2006 оны 12 дугаар сарын 13-нд улсын хэмжээнд ажиллаж эхэлсэн. Үндэслэгч нь Босни-Герцеговинийн Сэтгүүлчдийн Холбоо, Босни-Герцеговинийн Хэвлэн нийтлэгчдийн холбоо юм. Боснийн Хэвлэлийн Консул нь 1999 оноос Европын хараат бус Хэвлэлийн Консулуудын Альянсийн гишүүн болсон.

Одоо Хэвлэлийн Консул 15 гишүүнтэй. Бүрэлдэхүүн нь ихэвчлэн сэтгүүлчид болон хэвлэн нийтлэгчид. Хэвлэлийн Консулын тэргүүнээр Сараевогийн “Dnevni Avaz”

<sup>57</sup> www.vzs.ba

сонины Ерөнхий эрхлэгч С.Лукин ажиллаж байна. Харин гүйцэтгэх захирлаар Л.Журовак нарийн бичгийн дарга нарын газрыг хариуцаж ажилладаг.

Хэвлэлийн Консулын чуулган, удирдлагын зөвлөл, гомдол хүлээн авах хороо зэрэг бүтэцтэй.

2006 он хүртэл хэвлэн нийтлэгчид Хэвлэлийн Консулд оролцдоггүй байсан нь санхүүжилтэнд төдийгүй, нэр хүнд, гарах шийдвэрт хүртэл нөлөөлжээ. Одоогийн Консулын бүрэлдэхүүнд олон нийтийг төлөөлж хэвлэлийн байгууллагууд, хэвлэл мэдээлэлтэй ямар нэг байдлаар холбоотой байсан болон байгаа хүмүүс байгаа нь гарах шийдвэрт тэнцвэр алдагдах, хэт нэг талыг барихад хүргэдэг байж магадгүй юм.

### Санхүүжилтийн эх үүсвэр

Эдийн засагчийн нүдээр харвал Хэвлэлийн Консул нь хэвлэл мэдээллийн нэр дээр ирсэн тухайн гомдлыг үнэ төлбөргүй, хурдан, үр дүнтэй шийдвэрлэдгээрээ хуулийн тогтолцооноос ялгаатай гэж өөрсдөө үздэг. Энэ нь нэхэмжлэгч болон хариуцагч хоёулаа шүүхэд төлбөр төлдөг Босни-Герцеговинийн хуулийн заалттай холбоотой бөгөөд өмгөөлөгчийн хөлс, хэрэв мэдээллийн хэрэгсэл буруутвал нэхэмжлэгчид нэр төрд учирсан хохирлыг барагдуулж мөнгөн торгууль төлбөр өгөх тул хуулийн өмнөх шатанд шийдвэрлэхийг хичээдэг. Жишээлбэл: 2003-2004 онд зөвхөн Сараевогийн мужийн шүүхэд хэвлэлээс мөнгө нэхсэн 290 хэрэг гарсаны 102-ыг шүүхээр шийдвэрлэсэн юм. Үүнээс 62 нь Дээд шүүхэд давж заалдсаны 48 нь хэвлэлийн байгууллагыг 500-аас 4000 еврогоор торгох шийдвэр гарчээ. Гурван хэрэгт 10 000 еврогийн торгууль оногдуулжээ.

Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консул Олон улсын байгууллагуудаас санхүүждэг.<sup>58</sup> Хэвлэлийн Консул багаар бодоход дөрвөн жилийн дотор 440 623 еврогийн хандив гадаадаас хүлээн авчээ. Консулын үйл ажиллагааны зардал нэг жилд 110 мянган евро ногдож байгаа нь Недерланд, Израйль, Финлянд, Швейцарь зэрэг өндөр өртөгтэй орнуудын Хэвлэлийн Консулын жилийн төсвөөс давж байгаа юм.

Улс	Жилийн төсөв /евро/
Финлянд	165 000
Босни-Герцеговин	110 000
Израйль	83 000
Недерланд	75 000
Норвеги	600 000
Словак	1500
Швейцарь	120 000
Дани	200 000
Литва	28 000

<sup>58</sup> БГ-ийн Хэвлэлийн Консулыг Swedish International Development Agency (SIDA), European Commission, Босни дахь Их Бриатнийн ЭСЯ, Press Now, Босни дахь АНУ-ын ЭСЯ, Swedish Helsinki Committee for Human Rights, Open Society Institute, Council of Europe, Im-Pakt-Media зэрэг олон улсын хандивлагч байгууллагууд 2007 он хүртэл санхүүжүүлж байсан.

Гэтэл Литвийн Хэвлэлийн Консул Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консулын адил жилд 7 удаа хуралдаж, 200 хэрэг шийдвэрлэдэг ч жилийн төсөв нь дөнгөж 28 000 евро болдог. Харин Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консул 2002 онд 30 гомдол, 2003 онд 37 гомдол, 2004 онд 21 гомдол хүлээн авсан бол 2003 онд Их Британийн Хэвлэлийн Консул 3600 гомдол, Финлянд 128, Швед 383, Норвеги 207 гомдол шийдвэрлэжээ.

Яагаад вэ? Хэвлэлийн Консулын үйл ажиллагааны зардал ийнхүү өндөр байгаа нь нягтлан бодох бүртгэл байхгүй, санхүүгийн сахилга хангалтгүй, жилийн эцсийн санхүүгийн тайлан хангалтгүй, тодорхой биш байгаатай холбоотой байна. Хэн ямар үйл ажиллагаанд хэдийг зарсан нь тодорхойгүй байна. Жишээлбэл: төсвийн тайланд хүний хувьдаа зарсан зардлууд байна. Мөн байр офисийн түрээсийн мөнгийг төлсөн баримтын зэрэгцээ “бусад байр офисийн түрээс” гэсэн мөр байх жишээтэй.

Хоёр дахь шалтгаан нь Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консул гишүүддээ цалин хөлс өгдөг. Нэг удаагийн хуралд оролцоход 227.50 еврогийн цалин авдаг Босни-Герцеговинийн гишүүнтэй харьцуулахад Недерландын Хэвлэлийн Консулын гишүүн нэг уулзалтанд оролцоод 45 еврогоор цалинждаг нь тун бага санагдаж байгаа юм. Гишүүн цалингаас гадна жилд 16 760 еврогийн шагнал урамшуулал авдаг. Мөн Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консул уулзалтандаа 3-4 цаг хоцорч, хурлын бэлтгэлд нэг хоёр цаг л зарцуулдаг тул олигтой бэлтгэж амжилгүй ордог. Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консул санхүүгийн тусдаа зөвлөлгүй, сэтгүүл зүйн ёс зүйн дагуу гомдол шийдвэрлэхийн зэрэгцээ өөрөө өөрийнхөө ирэх жилийн төсвийг баталдгаас ийм зөрчил гардаг ажээ.

Үүний зэрэгцээ Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консул орон тооны 3 ажилтантай. Гүйцэтгэх Захирлын сарын цалин 1850 евро гэдэг нь Босни-Герцеговинийн хувьд маш өндөр цалин юм. Гомдол хүлээн авагч болон нарийн бичгийн цалин ч өндөр.

Энэ бүхний хажуугаар Хэвлэлийн Консул сайн хэвлэлийн төлөө кампанит ажил зохиох, хэвлэл мэдээллийн мониторинг явуулахад санхүүгийн дэмжлэг авдаг. 2004 онд Хэвлэлийн мониторингийн төсөл нь 48 788 еврогийн төсөвтэй байлаа. Мөн Хэвлэлийн Консулын нэр төрийг өргөх кампанит үйл ажиллагаанд 20 194 евро зарцуулжээ. Хэвлэлийн Консул сурталчилгаага сонинд байрлуулахдаа мөнгө төлж байгааг судлаачид онцлон шүүмжилдэг. Хэвлэл өөрийн Консулын сурталчилгаанд төлж байгаа нь буруу сигнал гэж үзэж байна.

## Дүрэм журам

Хэвлэлийн Консул 1999 оны 4 дүгээр сард Босни-Герцеговинийн Хэвлэлийн Консул, “БГ сэтгүүлчид” ассоциаци, Босни-Герцеговинийн Сэтгүүлчдийн Холбоо, Босни-Герцеговин дахь Хорват сэтгүүлчдин Холбоо, Сербийн БНУ-ын Сэтгүүлчдийн Холбоо хамтран баталсан Хэвлэлийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэхээр дараа жил нь байгуулагдсан. Хэвлэлийн Консул “Олон нийт үнэн зөв мэргэжлийн мэдээллээр хангагдах эрхтэй” гэж үздэг.

## БОСНИ-ГЕРЦИГОВИНИЙН ХЭВЛЭЛИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Европын Сэтгүүл зүйн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй стандартуудад түшиглэн боловсруулсан энэхүү дүрэм нь сонин, сэтгүүлийн эзэд, хэвлэлийн үйлдвэрийнхэн, редактор болон сэтгүүлчид даган мөрдөх ёс зүйн өөрийн зохицуулалтын тогтолцооны үндэс болох зорилготой. Сэтгүүлчид болон редакторууд нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс зүйн зарчмуудыг хүндэлж сэтгүүл зүйн мэргэжлийн нэгдмэл байдлыг хамгаалах ёстой. Энэ дүрэмтэй цуг бусад хууль журмууд Босни Герцеговиний хэвлэл мэдээллийнхний ажиллах үзэл баримтлалын суурь болно. Энэ дүрэмд БГ-ийг Мэргэжлийн Сэтгүүлчдийн Бие Даасан Нөхөрлөл, БГ-ийн Сэтгүүлчдийн Холбоо, Бүгд Найрамдах Серби улсын Сэтгүүлчдийн Бие Даасан Нөхөрлөл, БГ-ийн Холбооны Мэргэжлийн Сэтгүүлчдийн Холбоо хамтран гарын үсэг зурж мөн БГ дахь Хорват сэтгүүлчдийн холбоо хүлээн зөвшөөрч буй Харилцан Ойлголцлын Мэдэгдлийн үндсэн зарчмуудыг багтаасан болно.

Редакторууд болон хэвлэгчид хэвлэлийн энэхүү хуулийг харгалзах ажилтнууд нь энэхүү хуулийн талаар зохих мэдээлэлтэй болох асуудлыг хариуцна. Мөн тэд энэхүү хуулийн заалтуудыг бүрэн хүндэтгэн сахиулах үүрэг хүлээнэ. Энэ хуулийг 1999 оны 4 сарын 29-ны өдөр БГ-ийн Сэтгүүлчдийн бүх Холбоод хүлээн зөвшөөрсөн бөгөөд БГ-ийн Хэвлэлийн Зөвлөл, болон БГ дахь Сэтгүүлчдийн бүх холбоод энэ хуулинд 2005 оны 2 сарын 25, 2006 оны 8 сарын 24-нд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

### Нэгдүгээр зүйл: Ерөнхий заалтууд:

Сэтгүүлчид болон тэдгээрийн хэвлэн нийтлүүлсэн зүйлс нь цаг хугацааны ямар ч агшинд, ямар ч нөхцөл байдлын үед ёс зүйн дээд стандартуудыг даган баримтлах үүргийг олон нийтийн өмнө хүлээнэ. Ашиг тустай, цаг үеийн, учир холбогдолтой мэдээллийг авах иргэдийн хэрэгцээг хүндэлж, мэдээллийн эрх чөлөө, шударга санал шүүмжлэл тавих, шүүмжлэлт сэтгүүлзүй зэрэг үндсэн зарчмуудыг хамгаалах нь сэтгүүлчид болон хэвлэгчдийн үүрэг юм. БГ-дахь хэвлэл мэдээлэл нь иргэний нийгмийн нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс зүйн стандартуудыг баримтлан БГ дахь угсаатны, соёлын болон шашны олон янз байдлыг хүндэтгэнэ. Хэвлэл мэдээлэл нь хүний эрхийн тухай олон улсын болон БГ-ийн хууль, баримт бичгүүдийг даган мөрдөнө. Хэвлэл нь хүйсийн эрх тэгш байдал болон хувь хүнийг хүндлэх нь хүний эрхийн цогц ойлголтын салшгүй нэг хэсэг хэмээх ойлголтыг улам хөгжүүлэн ажиллана. Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн эрх ашгийн төлөө аливаа зүйлийг олж мэдэх эрхээ хадгалахын хамтаар хувь хүний эрхийг хамгаална. Энэхүү хуулийг энэ хоёр ойлголтын хүрээнд авч үзэх хэрэгтэй.

### 2-р зүйл: Редакторын хариуцлага:

Бүх ажилдаа баримтат үнэн болон уг үнэнийг мэдэх олон нийтийн эрхийг хүндэтгэж ажиллах нь сэтгүүлч сурвалжлагчдын хамгийн эрхэм хариуцлага билээ. Ямар ч үед сэтгүүлчид мэдээлэл цуглуулах, санал дүгнэлтээ илэрхийлэхдээ шударга ёс, үнэнч байдал, иргэншлийг хүндэтгэн ажиллана. Бусдын ажлаас хулгайлах, хуурамч баримт бүрдүүлэх, чухал баримтыг зориудаар нуун дарагдуулах, сэтгүүлчийн болон редакторын ажилд нөлөөлөх авилга, хахууль авах нь манай мэргэжлийн хамгийн ноцтой зөрчил юм.

### **3 дугаар зүйл. Турхирах:**

Хэвлэл мэдээлэл нь санаатайгаар эсвэл хайхрамжгүйгээс болж ялгаварлан гадуурхах, хүч хэрэглэх үзлийг хөөрөгдвөл ноцтой аюул үүсэж болно гэдгийг байнга ухамсарлаж ажиллана. Хэвлэл мэдээлэл нь энэ аюулыг ухамсарлаж буй тул гарал угсаа, яс үндэс, харьяалал, арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, бэлгийн баримжаа болон өөр бусад бие махбодийн буюу эсвэл оюун ухааны өвчлөл эсвэл дутагдлаас шалтгаалуулан үзэн ядалт эсвэл тэгш бус байдлыг дэмжих буюу хөөрөгдөхгүйн тулд чадах бүхнээ хийнэ. Ямар ч нөхцөл байдалд хэвлэл мэдээлэл нь гэмт хэрэг, хүчирхийлэлд турхирч болохгүй.

### **4-р зүйл: Ялгаварлан гадуурхах:**

Сонин, тогтмол хэвлэлүүд нь хүний угсаа гарал, үндэс харьяалал, шашин шүтлэг, хүйс, бэлгийн баримжаа болон өөр бусад бие махбодь, оюун ухааны өвчлөл, хомсдол, дутагдлын талаар үндэслэлгүй эсвэл доромжлох өнгө аястай дүгнэлт, үг хэллэг хэрэглэж болохгүй. Зөвхөн сурвалжилж буй зүйлтэй шууд холбоотой үед л хүний угсаа гарал, үндэс харьяалал, шашин шүтлэг, хүйс, бэлгийн баримжаа болон өөр бусад бие махбодь, оюун ухааны өвчлөл, хомсдол, дутагдлын талаар хөндсөн үг хэллэг хэрэглэж болно.

### **4а Зүйл: Хүйсийн эрх тэгш байдал, Хувь хүнийг хүндлэх:**

Хувь хүмүүсийг басамжлан харьцахад хүргэх, эсвэл секс, хүйс, бэлгийн баримжаа, хүйсийн илэрхийлэл, хүйсийн тодорхойлолт, бэлгийн тодорхойлолт зэрэг дээр үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад хүргэх шууд буюу шууд бус дүгнэлт хэлэхээс сонин сэтгүүлүүд зайлсхийнэ.

### **5 дугаар зүйл. Нягт нямбай байдал ба шударга тайлагнал:**

Сонин сэтгүүлүүд нь оновчтой бус, төөрөлдүүлсэн эсвэл мушгин гуйвуулсан материалыг зураг, текст буюу өөр ямарваа хэлбэрээр хэвлэн нийтлэхгүй байхын тулд чадах бүхнээ хийнэ. Зураг болон баримт бичгийг хуурамчаар хийх эсвэл төөрөлдүүлсэн байдлаар гаргах, мөн тухайн хэвлэн нийтэлж байгаа зүйлсийн тухай уншигчдын ойлголтонд материаллаг байдлаар нөлөөлөх хэмжээний чухал мэдээллийг дарагдуулж, саатуулж болохгүй. Хэрэв хэвлэн нийтэлсэн материал оновчтой бус нь тогтооогдвол сэтгүүлчид болон тэдгээрийн хэвлэлүүд нь уг мэдээллийг зөв болгон засах мэргэжлийн үүрэг хүлээнэ. Энэ тухай уучлал болон/эсвэл залруулгыг аль болох шуурхай нийтэлнэ. Аливаа сонин сэтгүүл нь ямарваа нэг мэдээллийг гажуудуулахад оролцсон бол түүнээс үүссэн үр дагаврыг үнэн шударга, оновчтойгоор нийтэлнэ. Сэтгүүлчид зөвхөн эх үүсвэр нь мэдэгдэж байгаа баримтыг үндэслэн мэдээлэл хийх болно. Харилцан зөрчил бүхий зүйлийг сурвалжлах, түүний талаар дүгнэлт хийхдээ сонин сэтгүүлүүд нь уг мөргөлдөөн (будилаанд) оролцогч бүх талуудыг сонсож, илэрхийлэхийн тулд хүчин чармайлт гаргана. Хэрэв мөргөлдөөнд аль нэг тал сэтгүүлчтэй харьцахаас татгалзвал хэвлэн нийтэлсэн зүйлдээ ингэж татгалзсан тухай зүй ёсоор дурдан бичиж болно.

### **6-р зүйл: Дүгнэлт, гаргалгаа, баримт:**

Сонин сэтгүүлүүд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ дүгнэлт, гаргалгаа болон баримтын хоорондох ялгааг нарийн баримтална.

### **7-р зүйл: Хариу өгөх боломж:**

Хэрэв хэвлэн нийтэлсэн зүйлсийн талаар хариу өгөх нь шударга ёс, ялгаварлан гадуурхахгүй байдлыг хангахад тусална гэж үзвэл хариу өгөх эрхийг холбогдох хүмүүст олговол зохино. Хэрэв боломжтой бол тухайн материал гарсан дугаарт уг материалыг эсэргүүцсэн хариуг өгөх боломж олгох хэрэгтэй.

### **8-р зүйл: Буруу илэрхийлэх:**

Сэтгүүлчид мэдээ, баримт, фото зураг авахдаа зөвхөн шударга зохистой арга хэрэгслийг ашиглана. Ямарваа хүний тухай ялган таних тодорхойлолт, түүний хүсэл зоригийг буруугаар илэрхийлэх, эсвэл хэвлэл мэдээлэлд тавих мэдээллийг хууран мэхэлж олж авах нь энэ мэдээлэл ноцтой нөхцөл байдалд олон нийтийн эрх ашгийн төлөө үйлчилнэ гэдэг нь илэрхий харагдаж байгаагаас бусад тохиолдолд маш ёс зүйгүй хэрэг болно. Сэтгүүлчид болон гэрэл зурагчид нь айлган сүрдүүлэх, өдөөн хатгах байдлаар мэдээлэл болон зураг олж авч болохгүй.

### **9-р зүйл: Хувийн амьдрал:**

Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн эрх ашгийн төлөө зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хүний хувийн амьдралийн талаар асуухгүй. Хүний хувийн эмгэнэлт явдалтай холбоотой түүх, намтрыг маш болгоомжтойгоор авч үзэх бөгөөд үүнд холбоотой хувь хүмүүстэй аль болох эелдэг, бөгөөд зүй ёсыг баримтлан харьцана.

### **10-р зүйл: Гэмт хэрэгт буруутгагдсан хүмүүс:**

Сонин сэтгүүлүүд нь шүүхийн шийдвэрээр тогтоогоогүй л бол хүнийг гэмт хэрэгтэн гэж харьцаж болохгүй. Сонин сэтгүүлүүд нь сэжиглэгдсэн хүний бурууг урьдчилан шүүх ёсгүй бөгөөд урьд нь хэн нэгэн хүний тухай хэрэг, байцаалт, шүүх ажиллагаа явж байгаа гэж мэдэгдсэн бол түүнийг цагаатгасан эсвэл шийтгэсэн тухай мөн мэдээлэх үүрэгтэй.

### **10а зүйл: Гэрчүүдийг хамгаалах:**

Сонин сэтгүүлүүд нь дайны гэмт хэргийн гэрчүүдийн талаар сурвалжлахдаа уг хамгаалалтанд буй гэрчүүдийг таниулахгүй байх дүрэм журмыг баримтлах талаар хүчин чармайлт гаргана. Сонин сэтгүүлүүд нь шүүх үйл явцыг бүрэн дүүрэн бөгөөд зөв шударга явуулахад зайлшгүй шаардлагатай бөгөөд үнэнийг буруугаар ойлгох, шүүхэд буруугаар нөлөөлөхгүйгээс бусад тохиолдолд дайны гэмт хэргийг шүүж байгаа үед гэрчүүдийг таньж тодорхойлохгүй байх, мөн тэдгээрийн төрөл садан, найз нөхдийг таньж тодорхойлохгүй байхыг эрхэмлэнэ.

### **11-р зүйл: Хүүхдүүд болон цөөнхийг хамгаалах:**

Хүүхдүүд болон цөөнхтэй харьцахдаа сэтгүүлчид туйлын хянамгай байх бөгөөд ёс зүйн хэм хэмжээ болон хүүхдийн сайн сайханд үндэслэсэн хүүхдийн эрхийн конвенцийг хүндэтгэн дагах ёстой. Сурвалжлагчид эцэг эх, эсвэл өөр насанд хүрсэн асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй буюу эсвэл эзгүйд нь 15-аас доош насны хүүхдээс гэр бүлтэй нь холбоотой асуудлаар ярилцлага авах буюу зургийг нь авч болохгүй. Олон

нийттэй хамаагүй үйл ажиллагааны хувьд сэтгүүлчид хүүхдийн нэр хаягийг илчлэхгүй хамгаалах үүрэгтэй. Сонин сэтгүүлүүд нь гэмт хэргийн хохирогч болсон 15-аас доош насны хүүхдийн нэр хаягийг тодорхойлохдоо маш болгоомжтой байж хариуцлагатай хандана. Сонин сэтгүүлүүд нь гэмт хэргийн гэрч эсвэл хохирогчоор оролцож байгаа 15-аас доош насны хүүхдийн нэр хаягийг тодорхойлж болохгүй.

#### **12-р зүйл: Сурталчилгаа ба ивээн тэтгэх:**

Арилжааны болон улс төрийн сурталчилгаа ба ивээн тэтгэсэн материалуудыг (нийтлэл буюу нэмэлт материалууд) редакцийн материалаас ялгаж авч үзнэ. Ивээн тэтгэсэн материалын хувьд ивээн тэтгэгч эх үүсвэрийг тодорхой, шуурхай зааж өгнө.

#### **13-р зүйл: Эх сурвалжаа нууцлах:**

Боломжтой бол сэтгүүлчид нээлттэй бөгөөд нэр хаяг нь тодорхой мэдээллийн эх сурвалжуудад тулгуурлаж ажиллах хэрэгтэй. Нэр үл мэдэгдэх эх сурвалжуудын үнэнч байдал, оновчтой байдлыг олон нийт хэмжиж чадахгүй учраас нээлттэй эх сурвалжуудыг сэтгүүлчид илүүд үзэх ёстой. Гэхдээ ил шуудаар нууцлахыг хүссэн ч хүсээгүй ч бай мэдээллийг нууцаар өгч байгаа этгээдүүдийн нэр хаягийг сэтгүүлчид болон тэдний нийтлэлийн бодлогоор хамгаалах ёстой.

#### **14-р зүйл: Эзэмшигчийн эрх ба зохиогчийн эрх:**

Сэтгүүлчийн хэвлэн нийтэлсэн зүйлд бусад нийтлэл эсвэл зохиогчийн эрхийг хөндөж болзошгүй материалаас тодорхой хязгаарлалттайгаар бага зэрэг ашиглах тохиолдол гарах бөгөөд энэ үед шуурхай зөвшөөрөл аваагүй байдаг бол уг эх сурвалжаа дурдаж өгөх нь зүйтэй. Зохиогчийн эрхээр хамгаалсан материалаас их хэмжээгээр хэрэглэх буюу эсвэл олшруулан ашиглахын тулд хэрэв зөвшөөрлийг уг материал дээрээ шууд заасан биш л бол уг зохиогчийн эрхийг эзэмшигчээс заавал тусгайлан зөвшөөрөл авна.

#### **15-р зүйл. Олон нийтийн эрх ашиг:**

Асуудлууд болон үйл явдлуудын талаар дүгнэлт хийж шийдвэр гаргах түүний дотор гэмт хэрэг болон ноцтой зөрчлүүдийг илчлэх мөрдөхөд нь олон нийтэд туслах мөн аливаа нэг хувь хүн эсвэл байгууллагын мэдэгдэл буюу үйлдлийн улмаас олон нийтийг төөрөлдүүлэхгүй байлгахын тулд гүйцэтгэсэн үйлдэл ба олсон мэдээлэл нь энэ хуулинд тусгасан олон нийтийн эрх ашгийн төлөө гэсэн ойлголт юм.

#### **16-р зүйл: Гомдол:**

Хэвлэн нийтэлсэн зүйл бүрийн хувьд гомдлыг хүлээн авах хариуцлагатай хэвлэн нийтлэгч буюу эсвэл редакторын нэр, хаяг, утас, факс, интернет болон и-мэйл хаягийг зохистойгоор байрлуулах шаардлагатай. Консулын ажилтнууд нь энэхүү хуулийн талаар мэдээлэлтэй байх асуудлыг редакторууд болон хэвлэн нийтлэгчид хариуцна. Мөн тэд энэ хуулийн заалтуудыг бүрэн мөрдүүлэх асуудлыг хариуцна. Энэ хуулийг зөрчсөн талаарх гомдлыг тухайн хэвлэн нийтэлсэн зүйлийг хариуцах хэвлэн нийтлэгч буюу эсвэл редакторт өгөх ёстой.

## Өргөдөл шийдвэрлэх механизм

- Хэвлэлийн ёс зүй зөрчсөн гэж үзвэл иргэн гомдол бүхий захидлыг тухайн сонин сэтгүүлд илгээхийн зэрэгцээ Хэвлэлийн Консулын нарийн бичгийн дарга нарын газарт тодорхойлж дэлгэрүүлсэн тайлбар, шаардлагатай бол хэвлэгдсэн сонингийн хамт илгээнэ. Гомдлыг факс, шуудан, цахим шуудангийн хэлбэрээр авна.
- Хэвлэлийн Консулын Нарийн бичгийн дарга уг захидлын дагуу гомдлыг хаягласан тухайн сонинтой холбоо барьж, хэрэв хэрэгтэй бол захидлын хуулбарыг Эрхлэгчид нь илгээж, тайлбар шаардаж, иргэн болон сонинны хооронд асуудлыг зохицуулна.
- Хэрэв зохицуулах боломжгүй гэж үзвэл Гомдол хүлээн авах хороонд гомдлыг шилжүүлнэ. Энэ хороо нь 9 гишүүнтэй: сонинны эздийн төлөөлөл 2, 2 сэтгүүлч, олон нийтийг төлөөлж Босни-Герцеговинийн 5 иргэний бүрэлдэхүүнтэй. Гомдол хүлээн авах хороо нь тухайн нийтлэл, таны гомдол, сонинны эрхлэгчийн хариу тайлбар зэргийг судалж үзээд Босни-Герцеговинийн Хэвлэлийн ёс зүйн хэм хэмжээнд үндэслэж шийдвэр гаргана. Шийтгэл нь зохицуулалт болно.

## Шийдвэрийг олон нийтэд мэдээлэх

Гомдлын талаарх Консулын шийдвэрийг уг маргаанд холбогдсон хэвлэлд харагдахаар хэвлэх болон мэргэжлийн сэтгүүлд нийтэлдэг. Хэвлэлийн Консул нь сэтгүүлчийг шийтгэх, торгох, болиулах эрхгүй.

Хэвлэл ба олон нийтийн дунд үүссэн асуудлыг зөвхөн сэтгүүл зүйн аргаар зохицуулдаг. Үүнд: залруулга гаргах, уучлал гуйх, няцаалт гэх мэт.

## Хууль зүй болон бусад асуудлууд

Босни-Герцеговин нь хэвлэл мэдээллийн салбарт олсон ололтоо баталгаажуулж бэхжүүлэх шинэ үе шатандаа орж, хууль эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо бүрдэж олон нийтийн мэдээллийн хэрэгслийн цаашдын хөгжилд суурь болж байна. Одоогийн байдлаар хэвлэл мэдээлэлтэй шууд холбоотой дараах хууль дүрмүүд үйлчилж байна:

- Гүжирдлэгийн тухай хууль
- Босни-Герцеговинийн Мэдээлэл олж авах эрх чөлөөний тухай хууль
- Босни-Герцеговинийн Олон нийтийн Нэвтрүүлгийн тухай болон Олон нийтийн нэвтрүүлгийн үндэс суурийн тухай
- Нэвтрүүлгийн мэргэжлийн ёс зүйн дүрэм
- Радио, Телевизийн зар сурталчилгааны болон ивээн тэтгэх тухай дүрэм
- Сонгуулийг сурвалжлах олон нийтийн мэдээллийн хэрэгслийн дүрэм
- Олон нийтийн нэвтрүүлгийн зорилго, журам





## Дүгнэлт

Олон улсын практикт хамгийн дэлгэрсэн хэвлэлийн хариуцлагын тогтолцоо болох Хэвлэлийн Консулын тухай судалж, Скандинавын орнууд, Англо-Саксон ардчилалтай орнуудын олон жилийн туршлага, төдийгүй шилжилтийн үедээ байгаа хуучин социалист оронд амжилттай ажиллаж байгааг хараад хэвлэлийн өөрийгөө зохицуулах ийм тогтолцоо манай хэвлэл мэдээлэлд хэрэгтэй байна гэсэн итгэл үнэмшил төрлөө. Дээрх судалгаанаас харахад Хэвлэлийн Консул хэвлэл мэдээллийн нийтлэл нэвтрүүлэгтэй холбогдож олон нийтээс гарсан гомдлыг шүүж, хэлэлцэн зохицуулж, мөн хэрэгтэй үед хэвлэлийн эрх чөлөөг хамгаалж байна.

- Хэвлэлийн Консулууд хараат бус бие даасан байгууллага.
- Үр дүнтэй ажиллах Хэвлэлийн Консул хэвлэл мэдээллийн эсрэг үүсэх эрүүгийн болон иргэний хэргийг цөөлнө.
- Шүүхийн өмнөх шатанд сэтгүүлч ба нэхэмжлэгчийг эвлэрүүлэх журмаар хэргийг шийдсэнээр шүүхээр шийтгэгдэх сэтгүүлчдийн тоог цөөлнө.
- Хэвлэлийн эсрэг гомдлыг сэтгүүлчийн эсрэг биш, харин хэвлэл мэдээллийн байгууллагад хаяглаж гаргаж байна.
- Хэвлэлийн Консул, хэвлэлийн өөрийгөө зохицуулах тогтолцоо нь хэвлэл мэдээлэл болон эрх баригчдын хоорондох тэмцлийн үр дүн юм. Хэвлэлийн Консул байгуулагдсан, шинэчлэгдсэн бүх түүхийн үндэс нь хөшигний цаадах тэмцэл байжээ.
- Хэвлэлийн Консулын бүтцийн нэг чухал бүрэлдэхүүн нь хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид, эрхлэгч нарын корпорацичлагдсан хольц байна.
- Хэвлэл мэдээллийн салбар Консулын үйл ажиллагааны зардлыг бүрэн санхүүжүүлж байна.
- Консулын үйл ажиллагааны төсвийг батлах бүтэц тусдаа байх нь санхүүгийн сахилга бат алдагдахаас сэргийлж байна
- Консулын үйл ажиллагааны стандартыг нь үнэлэх, ёс зүйн дүрэм шинэчлэх бүтэц нь Консулаас тусдаа байна.
- Ёс зүйн дүрэмд хэвлэл мэдээллийн мэдээ нийтлэл нэвтрүүлэг хамаарахаас сурталчилгаа реклам хамаарахгүй.

- Ёс дүрмүүдийн хэм хэмжээнүүд нь хоорондоо төстэй, ерөнхий агуулгатай бичигдсэн байна. Харин Недерландын хувьд ийм бичмэл дүрэмгүй.
- Мөнхийн маргаан болсон чөлөөт хэвлэл (хуулиар хамгаалагдсан) ба шударга хэвлэлийн (хэвлэлийн ёс зүйн хэм хэмжээг дагадаг) асуудлыг Хэвлэлийн Консул шийдэж байна
- Скандинавын орнуудад эрх баригчид, Хэвлэлийн Консулын хооронд хамтын ажиллагаа харагдаж байгаа бол Их Британийн хувьд хөндлөнгөөс оролцохоос болгоомжилсон хандлага хүчтэй байна.
- Хэвлэлийн Консулуудын үйл ажиллагаа тунгалаг, жил бүрийн тайлан нь олон нийтэд ил тод байна. Их Британи өөрийн жилийн тайлангаа хэвлүүлж, бас вэбсайтдаа тавьжээ.

Хэвлэлийн Консул нь өөрийн гаргасан шийдвэрээ нийтлүүлэх ганцхан зэвсэгтэй.

Магадгүй энэ нь Эрүүгийн хуулийн хатуу заалтуудыг сэтгүүлчдийн эсрэг хэрэглэж байгаа манай тохиолдолд “чоно цатгалан, хонь бүрэн” байх ганц хувилбар ч байж болох юм. Хэвлэлийн Консул нь сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдүүлж, нөгөөтэйгүүр сэтгүүлчийн нэрээр хаягласан гомдлыг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх журмаар шийдсэнээр сэтгүүлчдийг хамгаалж чадна гэдэгт итгэж байна.

Хэвлэлийн Консулуудын үйл ажиллагааг сонгосон улсуудаар харьцуулбал:

	Дани	Их Британи	Недерланд	Швед	Босни-Герцеговин
<b>Хариуцлагын систем</b>	Данийн Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хуулинд үндэслэн, хэвлэл мэдээллийн байгууллагын талаар гаргасан гомдлыг авч хэлэлцдэг бие даасан хараат бус олон нийтийн шүүх	Сайн дурын болон хууль зүйн систем зэрэгцэн оршдог.	Сайн дурын системтэй	Сайн дурын системтэй. Хэвлэлийн консул болон Хэвлэлийн Омбудсмэний алба ажилладаг.	Сайн дурын системтэй
<b>Хэвлэлийн Консулын Үүрэг</b>	Хэвлэл Мэдээллийн хариуцлагын хуулийг мөрдүүлэх	Олон нийтийн гишүүдийн зүгээс сонин сэтгүүлийн нийтлэлийн талаарх гомдлыг хэлэлцдэг бие даасан хараат бус байгууллага	Ёс зүйгүй сэтгүүлчдээс иргэдийг хамгаалах	Сайн сэтгүүл зүйн үзэл баримтлалыг практикт хэрхэн хэрэглэснийг шалгах	Хэвлэлийн эсрэг иргэдийн гомдлыг авч үзэж, маргаан хэрүүлийг боломжтой сэтгүүл зүйн аргаар шийдвэрлэх

	Дани	Их Британи	Недерланд	Швед	Босни-Герцеговин
<b>Бүтэц</b>	8 гишүүнээс бүрдэнэ. Дарга болон дэд дарга нь хуульч хүмүүс байх ёстой бөгөөд Данийн Дээд Шүүхийн зөвлөмжөөр томилдог. Бусад 2-Данийн Сэтгүүлчдийн Холбоо, 2-хэвлэл радио телевиз, 2-Данийн Насанд хүрэгчдийн Боловсролын Консулын зөвлөмжөөр олон нийтийн төлөөлөл болж томилогдоно.	17 гишүүнтэй. Даргыг хэвлэлээс томилдог. Олон нийтийн төлөөлөл болон Хэвлэлийн төлөөллийг хараат бус Албан тушаалд томилох комисс томилно.	Сангийн Удирдах Зөвлөл Хэвлэлийн Консулын гишүүд, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилдог. Хэвлэлийн Консул нь 4 дэд дарга, 13 сэтгүүлч, 13 сэтгүүлч бус гишүүдээс бүрдэнэ. Консулын дарга болон гишүүд энэ ажлаа жирийн ажлынхаа зэрэгцээ хийдэг	Дарга нь шүүгч, Хэвлэлийн Консулыг бүрдүүлдэг Шведийн Сонин хэвлэн нийтлэгчдийн холбоо, Шведийн Сэтгүүлчдийн Эвлэл, Үндэсний Пресс клуб өөрийн 4 төлөөлөгч, сонин хэвлэлийн бизнестэй холбоогүй, олон нийтийн 3 төлөөлөгч.	6 сэтгүүлч, 6 олон нийтийн төлөөлөгч, олон улсын байгууллагаас томилогдсон даргатай
